



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ЖИЛИЙН ТАЙЛАН

2023

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГ3

ӨМНӨХ ҮГ4

АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛ

Ардчиллын институцуудыг бэхжүүлэх хөтөлбөр6

 Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд7

 УИХ-ын Сонгуулийн тухай хуулийн эргэн тойронд8

 Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлд оруулсан хувь нэмэр11

 Үзэл бодлоо илэрхийлэх эрх, мэдээллийн ил тод байдлын асуудлаар13

 Хүний эрхийн асуудлаарх нөлөөллийн ажил17

Иргэний нийгмийн орон зайн хөтөлбөр21

 Иргэд, ИНБ-үүдэд хүргэх шинэ мэдээлэл, шинэлэг үр чадвар21

 Иргэний оролцооны механизмуудыг сурталчлан таниулах түншлэл25

 Төсвийн хуваарилалтад иргэдийн шууд оролцоо28

 Ардчиллын, сонгогчийн чухал үр чадвар болох мэдээллийн боловсрол29

ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГО

Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх хөтөлбөр34

 Шүүх эрх мэдлийн индекс34

 Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ37

НИЙТИЙН БАЯЛГИЙН УДИРДЛАГА, ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ

Төсвийн хариуцлагыг дээшлүүлэх хөтөлбөр40

 Төсөв, санхүүгийн удирдлагыг хөгжлийн бодлогод чиглүүлэх нь40

 Төсвийн хяналт, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээрх иргэний нийгмийн үйл ажиллагаа46

Эрдэс баялгийн салбарын засаглалын хөтөлбөр48

 Эрх зүйн шинэчлэлийг дэмжих48

 Төрийн өмчит компанийн засаглалыг бэхжүүлэх51

 Нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах55

САНХҮҮГИЙН ТАЙЛАН57

ТОВЧИЛСОН ҮГ

АСДОУХ Ардчилал, сонгуулийг дэмжих олон улсын хүрээлэн

АТ6ХЭОУТ Ашгийн төлөө бус хулийн этгээдийн олон улсын төв

БЗД Баянзүрх дүүрэг

БШУ Боловсрол, шинжлэх ухаан

БНМАУ Бүгд Найрамдах Монгол Ард Улс

БОАЖЯ Байгал орчин аялал жуулчлалын яам

ЕБС Ерөнхий боловсролын сургууль

ЗДТГ Засаг даргын тамгын газар

ЗЕХ Захиргааны ерөнхий хууль

ИНБ Иргэний нийгмийн байгууллага

ИТХ Иргэдийн төлөөлөгчдийн хурал

МХХ Монголын хуульчдын холбоо

МУИС Монгол Улсын Их Сургууль

МЭССТ Монголын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн төв

ННФ Нээлттэй Нийгэм Форум

ШСХ Шүүхийн сахилгын хороо

ШЕЗ Шүүхийн Ерөнхий зөвлөл

ОНХС Орон нутгийн хөгжлийн сан

ОУТТ Олон улсын төсвийн түншлэл

СЕХ Сонгуулийн Ерөнхий хороо

СҮИС Сөүлийн үндэсний их сургууль

ТББ Төрийн бус байгууллага

ТӨК Төрийн өмчит компани

ТҮЗ Төлөөлөн удирдах зөвлөл

УДШ Улсын дээд шүүх

УИХ Улсын Их Хурал

УУХҮЯ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

ХЗДХЯ Хууль зүй дотоод хэргийн яам

ХХК Хязгаарлагдмал хувьцаат компани

ХК Хувьцаат компани

ХНХЯ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

ХСИС Хууль сахиулахын их сургууль

ХЗС Хууль зүйн сургууль

ХХН Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл

ХЭҮК Хүний эрхийн Үндэсний комисс

ШЕЗ Шүүхийн ерөнхий зөвлөл

ШСХ Шүүхийн сахилгын хороо



Нээлттэй Нийгэм Форум (ННФ) нь 2004 онд байгуулагдсан цагаасаа эхлэн ардчилсан сайн засаглал, нийтийн баялгийн удирдлага, эрх зүйн шинэтгэлийн бодлогын түлгэмдсэн асуудлуудыг иргэний нийгмийн зүтгэлтнүүд, эрдэмтэн судлаачидтай хамтран судлах, шинжилгээ, мониторинг хийн үр дүнг бодлого боловсруулагчид болон олон нийтэд хүргэж улс орныхоо хөгжилд хувь нэмэр оруулахыг зорин ажиллаж ирлээ. Манай байгууллага 2023-2025 оны үйл ажиллагааны үндсэн чиглэлээ ардчиллын институтуудыг бэхжүүлэх, иргэний нийгмийн орон зайг тэлэх, шүүхийн хараат бус байдлыг дээшлүүлэх, нийтийн баялгийн удирдлага, ил тод хариуцлагатай байдлыг сайжруулах хэмээн тодорхойлсны дагуу тайлант оны үйл ажиллагаагаа зохион байгуулж хэрэгжүүлээ.

2023 он манай улсын хувьд парламентын төлөөлөх чадварыг нэмэгдүүлэн олон намын тогтолцоог дэмжих үндсэн дээр ардчиллыг түүштай гүнзгийрүүлэн хөгжүүлэх зорилго агуулсан Үндсэн хуулийн 2019, 2023 оны нэмэлт, өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох зохицуулалтуудыг хууль тогтоомжид тусгах, зарим хуулийг шинэчлэн найруулах үйл явц өрнөсөн онцлог жил боллоо. Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэн баталснаар улс төрийн намын санхүүжилтийг ил тод, хяналттай болгох зэрэг дэвшилтэт зохицуулалтууд тусгалаа олсны зэрэгцээ улс төрийн намууд бодлогын нам болон өөрчлөгдөх суурь тавигдлаа. ННФ-ын төлөөлөл энэхүү хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт нь багтан ажиллахын зэрэгцээ холбогдох олон улсын байгууллагуудаас санал шүүмж авах, сэтгүүлчид, иргэний нийгмийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэх, гаргасан санал зөвлөмжийг



шийдвэр гаргагчдад хүргэх зэргээр дэмжлэг үзүүлж хамтран ажилласан юм.

УИХ-ын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулж байгаатай холбогдуулан “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ”-ний гишүүн байгууллагуудтай хамтран 2020 оны сонгуулиар хийсэн ажиглалт, тэдгээрийг дагалдуулан хийгдсэн судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой зөрчлийг шийдвэрлэх, сонгуулийн зардлыг бууруулах болон санхүүжилтийн ил тод байдал, хяналтыг сайжруулах талаар зөвлөмж боловсруулан бодлого боловсруулагчдад хүргэлээ. Үүний үр дүнд сонгуульд ажиглалт, мониторинг хийх ТББ-ууд нийт нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дэлгэрэнгүй тайланг бүрэн эхээр нь авч хяналт тавих нөхцөл бүрдсэн юм. Сонгогчдын нэрийн жагсаалтад хийсэн ажиглалт, хэлэлцүүлгүүдийн үр дүнд сонгогч нэрийн жагсаалтад өөрт хамаарах

мэдээллээс гадна тухайн хаяг дээр бүртгэлтэй бусад хүмүүсийн мэдээллийг шалгах, зөрүүтэй мэдээллийн талаар гомдол гаргаж шийдвэрлүүлэх, сонгогчдын нэрийн жагсаалтын нэгдсэн сантай байх, сонгуульд оролцсон сонгогчийг нэгдсэн серверт санал өгсөн гэх тэмдэглэгээ тавьж ирцийн мэдээг шуурхай гаргах боломжтой болов.

Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд иргэний нийгмийн ээлтэй эрх зүйн орчин бүрдүүлэх, иргэний нийгмийн байгууллагуудын хүний эрх, нийтийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр явуулж буй олон талт үйл ажиллагааг олон нийтэд таниулах, нийгмийн өмнө шинэ тутам тулгамдаж буй төвөгтэй асуудлуудыг авч үзэхэд шаардагдах мэдлэг, үр чадвар эзэмшихэд нь иргэний нийгмийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаа хэрэгжүүлээ. ТББ-ын цахим аюулгүй байдал, нийгмийн сүлжээн дэх хуурамч мэдээллийг таних, бодлогын судалгааны



арга зүйн асуудлаар зохион байгуулсан сургалтад хот хөдөөгийн ТББ-ын 120 гаруй ажилтан оролцов. Тэрчлэн, ТББ-уудад үрт хугацааны дэмжлэг үзүүлэх “Иргэний нийгмийн гэр” төслөө энэ онд үргэлжлүүлээ. 2017 онд эхлүүлсэн уг төсөл нь тодорхой шалгуурын дагуу сонгогдсон ТББ-уудыг оффисын байраар хангах замаар тэдний санхүүгийн дарамтыг бууруулж, үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад нь хувь нэмэр оруулах зорилготой юм. Энэ удаад “Цогцхөгжлийн төлөө үндэсний төв”, “Бодлогод залуусын хяналт”, “Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо”, “Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэн”, “Хөгжлийн төлөө өгөгдөл”, “Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв” ТББ-уудад энэхүү байрыг 3 жилийн хугацаанд ашиглах эрхийг олголоо.

Манай улс 2021 онд Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль баталснаар иргэний нийгмийн орон зай саадтай ангиллаас нэг шат дэвшсэн ч энэ нь хангалттай үзүүлэлт биш болохыг олон улсын байгууллагын үнэлгээ харуулж байна. Иймээс төрийн бус байгууллагын эрх зүйн орчныг боловсронгуй болгон үйл ажиллагааны хараат бус байдлыг хангах, үр нөлөөтэй, тогтвортой ажиллах нөхцөлүүдийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах болно.

ННФ нь олон жилийн туршид нийтийн зөрчигдсөн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэл гарган хамгаалах арга механизмыг дэлгэрүүлэхэд анхаарч ажиллаж ирсэн бөгөөд 2023 онд “Хил хязгааргүй хуульчид” ТББ-ын энэ талаарх санаачилгыг дэмжсэн нь хуульчид, хуулийн сургуулийн оюутнуудад энэхүү арга зүйг эзэмшүүлэхэд чухал алхам боллоо.

Манай улсад эрх зүйн шинэтгэл, өөрчлөлт тасралтгүй хийгдэж, зарим дэвшилтэт зохицуулалт бий болж байгаа ч эдгээр нь түүштай хэрэгжихгүй, эргүүлж буцаах явдал цөөнгүй гарч байгаагийн улмаас шударга ёсны салбарт тулгамдсан асуудлууд хуримтлагдсан хэвээр байна. Монгол Улсад хууль ёсыг сахиулахад нэн чухал үүрэгтэй УДШ-ийн шүүгч, Цэцийн гишүүн,

Улсын ерөнхий прокурорын томилгооны улс төрөөс хараат бус байдлыг хангахад чиглэсэн томилгооны сонголыг Үндсэн хуулийн цэцээс хүчингүй болгох шийдвэр гаргасан нь үүний нэг тод жишээ болж байна. ННФ нь Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэчлэлийн үйл явцад бие даасан судалгаа, мониторингийн дүнг нийлүүлэхийн зэрэгцээ, шинэ эрх зүйн орчинд ажиллах эрх зүйн соёлыг төлөвшүүлэх, хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг боловсруулах шатанд иргэний нийгмийн санал бодлыг нэгтгэн хүргэхийг зорин ажиллаж ирлээ. 2023 оны хувьд хохирлын үндэсний тогтолцоог бэхжүүлэх зорилгоор хийгдсэн багц судалгааны дөрөв дэх болон гэмт хэргийн улмаас учирсан хохирол тооцох олон улсын харьцуулсан судалгааны тайлан, өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх бодлогын хоёр судалгаа, прокурорын байгууллагын үйл ажиллагааны хараат бус, ил тод байдлыг үнэлэх хоёр судалгаа, шүүхийн шийдвэрийн цахим сан болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мониторинг зэрэг судалгааг захиалан гүйцэтгэж олон нийтийн хүртээл болгоод байна.

Нийтийн санхүүгийн удирдлагыг эдийн засгийг төрөлжүүлэн ажлын байрыг нэмэгдүүлэх, эрчим хүчний хараат байдлыг бууруулахад чиглүүлэн зохистой хэрэгжүүлэх, үрэлгэн зардлыг танах шаардлага нэн тулгамдаж байна. Энэ хүрээнд хараат бус судлаачидтай хамтран 2024 оны улсын төсвийн төлөвлөлт, төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж олон нийтээр хэлэлцүүлсний зэрэгцээ Монгол Улсын төрийн гадаад өрийн хэмжээ, түүний цаашдын төлөв байдлыг тооцоолж, өрийн тогтвортой байдалд дүгнэлт өглөө. Тэрчлэн, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлт, цалин болон халамжийн бодлого иргэдийн ажил эрхлэлтэд үзүүлж буй нөлөөлөл, хувь хүний орлогын албан татварт хамрагдаж буй орлогын эх үүсвэрүүд, жижиг, дунд үйлдвэрлэлийн салбар дахь гарааны бизнест импортын нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулалтыг боловсронгуй

болгох зэрэг чиглэлээр судалгаа хийж, зөвлөмж гаргалаа.

ННФ-ын дэргэдэх Төсвийн Зөвлөл улсын төсөв, санхүүгийн чухал асуудлуудыг тогтмол хэлэлцэж, санал зөвлөмжөө УИХ-ын Төсвийн байнгын хороонд хүргүүлж ажилласнаар энэ онд нийтийн төсөв, санхүүгийн удирдлагын эрхзүйн орчныг боловсронгуй болгоход багагүй хувь нэмэр орууллаа. Тодруулбал, төсвийн удирдлагыг боловсронгуй болгох, төсвийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог хангах чиглэлээр нааштай заалтууд Төсвийн тухай хуульд ороод байна.

Эрдэс баялгийн салбарын засаглалын хөтөлбөр нь салбарын эрх зүйн шинэчлэлийг судалгаа, нотолгоонд суурилсан мэдээллээр хангахыг зорьж, бодлогын хэлэлцүүлэгт эрх ашиг нь хөндөгдсөн бүхий л талын оролцоог хангах, ялангуяа уул уурхайн бүсэд оршин суугч иргэдийн дуу хоолойг хүргэхэд чиглүүлэн ажиллалаа. Тэрчлэн төрийн өмчит компанийн засаглалд олон улсын стандартыг нэвтрүүлэхэд чиглэсэн бодлогын цуврал судалгаа хийж, холбогдох талуудад хүргээд байна. Харамсалтай нь 2020 оноос хойш дуншиж буй салбарын засаглалыг сайжруулахад чиглэсэн эрх зүйн шинэчлэлт зогсонги хэвээр үлдэж, төрийн өмчит компаниудтай холбоотой авлига, ашиг сонирхлын асуудлыг “бүрэн эрхт төлөөлөгч” томилж, “нүүрсний” гэж нэрлэгдсэн нээлттэй сонголт хийгээд ч нэг мөр цэгцэлж чадаагүй хэвээр байна. Энэ нь уг салбарт засаглалын тулгамдсан асуудлуудаарх бодлогын хэлэлцүүлгийг эрчимжүүлж, эрх зүйн шинэчлэлийг дэмжих нийгмийн зөвшилцлийг холбогдох талуудын дунд бий болгох хэрэгцээ шаардлага буйг илэрхийлж байна.

Уур амьсгалын өөрчлөлт, цар тахал, геополитикийн нөхцөл байдал зэрэг бүс нутаг, олон улсын хэмжээнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд бүс нутгийн улс орнуудын хамтын ажиллагаа нэн чухал болж байна. Улаанбаатар хотноо жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Зүүн Хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа хэлэлцээ” VIII бага хүрлын хүрээнд “Залуучуудын форум” зохион байгуулахад ННФ-аас дэмжлэг үзүүлэв. “Хамтарсан ирээдүйг тодорхойлох нь” сэдвийн хүрээнд болсон энэхүү форумаар Монгол Улс, АНУ, БНКаЗУ, БНСУ, Швед, БНХАУ зэрэг улсыг төлөөлсөн нийт 25 залуу “Өнөөгийн хямралуудаас суралцах нь”, “Хүртээмжтэй ардчилсан нийгмийг цогцлоох” болон “Технологи, харилцаа, холболт” гэсэн сэдвийн хүрээнд санал солилцон хэлэлцүүлэг өрнүүлээ.

Эцэст нь тэмдэглэхэд сорилт бэрхшээл ихтэй, үйл явдал өрнүүн жилд үйл ажиллагааныхаа шинэчилсэн стратегийн дагуу төлөвлөсөн ажлаа тасралтгүй явуулж, үр дүнг нь товчлон нэгтгэж Та бүхний сонорт хүргэж байна. Бидний үйл ажиллагааг дэмжин, хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагууд, судлаачид, мэргэжилтнүүддээ болон манай үйл ажиллагааг сонирхон оролцож мэдлэг, туршлага, үзэл бодлоо хуваалцдаг хүмүүст талархал илэрхийлье.

Хэрвээ танд энэхүү тайлан болон бидний үйл ажиллагаатай холбогдох санал байх аваас osf@forum.mn хаягаар ирүүлнэ үү. Бид таны саналыг таатай хүлээн авах болно.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал  (П.Эрдэнэжаргал)

ИРГЭНИЙ НИЙГМИЙН АЖИГЛАЛТ



АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛ

АРДЧИЛЛЫН ИНСТИТУЦУУДЫГ БЭХЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР



2023 оны эхний хагаст ардчилсан тогтолцоо, засаглалд чухал нөлөө бүхий томоохон бодлогын өөрчлөлтүүд шил шилээ даран тохиов. Монгол Улсын Их Хурал (УИХ)-аас 2023 оны 5-р сарын 31-ний өдөр Үндсэн Хуульд тусган баталсан нэмэлт өөрчлөлтийг юуны түрүүнд онцлох нь зүйтэй. Уг өөрчлөлтийн хүрээнд УИХ-ын 76 сүүдлыг 126 болгон 50 гишүүнээр нэмэгдүүлсэн бөгөөд УИХ-ын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулна, чингэхдээ "78 гишүүнийг олныг төлөөлөх, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно" хэмээн тусгажээ. Энэхүү өөрчлөлтийг даган УИХ-ын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэн батлах ажлууд өрнөлөө.

ННФ-ын зүгээс бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад иргэд, иргэний нийгмийн идэвхтэй оролцоог дэмжих, чанартай мэдээлэл, судалгаанд үндэслэсэн бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэх эрхэм зорилгынхоо хүрээнд бодлогын үйл явцыг судалгаа шинжилгээгээр дэмжих, бодлого боловсруулагчдад шаардлагатай

техникийн туслалцаа үзүүлж хамтран ажиллах, эрх зүйн хүрээнд гарч буй шинэчлэлийн талаарх мэдээллийг сэтгүүлчид, иргэний нийгмийн төлөөлөлд танилцуулан хэлэлцүүлэх, иргэний нийгмээс гаргасан санал зөвлөмжийг шийдвэр гаргагчдад хүргэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа.

Үндсэн хуульд туссан өөрчлөлтийг угтан 2023 оны 2-р сард УИХ-аас "Зөвлөлдөж шийдье" зөвлөлдөх санал асуулга зохион байгуулж, иргэний улс төрийн эрх, авлигатай тэмцэх асуудал, төрийн хариуцлага, ил тод байдал, хяналт, улс төрийн санхүүжилтийн ил тод байдал, парламентын ардчиллыг бэхжүүлэхтэй холбоотой асуудлаар иргэдийн санал бодлыг сонссон юм. УИХ-аас ННФ-д хандан энэхүү үйл ажиллагаанд оролцох хүсэлт тавьсныг хүлээн авч, улс төрийн намын гишүүнчлэл, бодлогын нам, улс төрийн санхүүжилтийн ил тод байдлын асуудлаар мэдээлэл, нийтлэл бэлтгэн, эх орны өнцөг булан бүрээс санал асуулгад оролцохоор зорин ирсэн 900 орчим оролцогчид танилцуулж, хэлэлцүүлэв.



"Зөвлөлдөж шийдье" Үндэсний форум. Баруун гар талаас ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Энхцэцэг, Төрийн ордон. 2-р сарын 15

Уг зөвлөлдөх санал асуулгын явцад төрийн ерөнхий хяналтын чиг үүрэг бүхий институци шинээр бүрдүүлэх тухай санал хүчтэй хөндөгдсөн ба төрийн эрх мэдлийн хуваарилалтад ерөнхий хяналтын эрх, үүрэг хэрэгжүүлдэг эрх мэдлийн тав дахь салаа мөчир бүхий цор ганц орон болох Тайван Улсын "Хяналтын юань"-ийн талаар мэдээлэл бэлтгэн оролцогч талуудад хүргүүлж


ажиллалаа. Хариуцлагын босоо тогтолцоо буюу төрийн хяналт шалгалтын тогтолцоог Монгол улсад төвлөрсөн бус байдлаар зохион байгуулсан байдаг нь зарим сул талтай байж болох ч эрх мэдлийн хэт төвлөрлөөс үүдэх эрсдэлээс зайлсхийх боломж олгох сайн талтайг ч санах нь чухал юм.

ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН ХҮРЭЭНД

Үндсэн хуулийн өөрчлөлтийн хүрээнд парламентын төлөөллийн чадавхыг нэмэгдүүлэх тухай асуудал нэлээд хөндөгдсөн бөгөөд үүнд парламентын сүүдэлд ногдох иргэдийн тоог голлон авч үзэх хандлага түлхүү ажиглагдав. Парламентын төлөөллийн чадавх нь агуулгын хувьд зөвхөн парламентын сүүдлын тоогоор илэрхийлэгдэхгүй, өргөн хүрээтэй ойлголт билээ. Тухайлбал, олон улсын парламентын холбооноос гаргасан парламентын үнэлгээний аргачлалд Ардчилсан парламент нь төлөөллийн, нээлттэй, ил тод, хариуцлагатай байгууллага болохыг тодорхойлоод парламентын төлөөлөх чадавх нь нийгмийн болоод улс төрийн хувьд хүртээмжтэй байх тухай асуудал хэмээн тайлбарласан байдаг. Үүнд, гишүүд нь мандатын хүрээнд эрх, үүргээ чөлөөтэй хэрэгжүүлэх,

үзэл бодлоо илэрхийлэх, ялангуяа сөрөг хүчний гишүүд нь ялгаварлалд өртөлгүй үгээ хэлэх боломжтой байх, түүнчлэн бүрэлдэхүүний хувьд эрэгтэй, эмэгтэй хүйсийн төлөөлөл бүхий байхыг хэлэхээс гадна сонгууль нь чөлөөт, шударга зарчмаар явагддаг, улс төрийн намууд нь дотооддоо нээлттэй, ардчилсан систем нэвтрүүлсэн байх гэх мэт олон шалгуурыг дурдсан байна.

Энэ тухай онолын болон эмперик судалгаанд үндэслэсэн тэнцвэртэй мэдээлэл сонирхогч талуудад хүргэх зорилгоор МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш, доктор Г.Туяагэрэлийг урин, парламентын төлөөлөх чадавхыг хэмжсэн судалгааны урьдчилсан үр дүнг танилцуулах уулзалтыг 6-сарын 9-нд зохион байгуулав.



Парламентын төлөөлөх чадварыг Монгол Улсын жишээн дээр үнэлсэн анхны судалгааны урьдчилсан үр дүнгийн талаар сэтгүүлч, судлаач, иргэний нийгмийн 40 гаруй төлөөлөл шимтэн сонирхож, Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, сонгуулийн тогтолцооны өөрчлөлт нь дангаараа парламентын төлөөлөх чадварыг нэмэгдүүлэхэд хангалттай эсэх талаар сонирхолтой хэлэлцүүлэг


өрнүүлсэн юм. Энэхүү хэлэлцүүлгээр мөн УИХ-ын үйл ажиллагааны ил тод байдалд иргэний нийгмийн байгууллагын хийсэн мониторингийн үр дүнг танилцуулж, цаашид олон нийтэд нээлттэй, ил тод, хариуцлагатай парламентыг бэхжүүлэх чиглэлд холбогдох хуулиудад ямар арга хэмжээг тусган хэрэгжүүлэх нь зүйтэй талаар санал солилцсон юм.

УИХ-ЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЭРГЭН ТОЙРОНД

УИХ-аас 2023 оны 6-р сарын 16-нд УИХ-ын Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж баталлаа.

хуульд тусгахаар боловсруулсан нэмэлт өөрчлөлтийн төсөл, түүнд иргэний нийгмийн зүгээс өгсөн зөвлөмжийг сэтгүүлч, судлаачдад танилцуулах хэлэлцүүлэг зохион байгуулав.


ННФ-аас Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний гишүүн байгууллагуудтай хамтран өмнөх сонгуулиар хийсэн ажиглалт, тэдгээрийг дагалдуулан хийгдсэн судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой асуудлыг нааштайгаар шийдвэрлэх, сонгуулийн зардлыг бууруулах болон санхүүжилтийн ил тод байдал, хяналтыг сайжруулах талаар зөвлөмж боловсруулан бодлого боловсруулагчдад хүргэв. Үүний зэрэгцээ сэтгүүлчид болон олон нийтэд мэдээлэл хүргэх, хуулийн төслүүд танилцуулах цуврал уулзалт, хэлэлцүүлгийг цаг тухайд нь зохион байгууллаа. Үүнд, 2023 оны 5-р сарын 18-нд СЕХ-ны Ажлын албатай хамтран УИХ-ын сонгуулийн



ННФ-ын зүгээс сонгуулийн үйл явцын ил тод, шударга байдлыг хангахад иргэний нийгмийн хяналт тавих оролцоог чухалчлан байнга дэмжиж ирсэн билээ. Иргэний нийгмийн ажиглалт, мониторинг нь сонгуулийн үйл явцад маргаан дагуулж болзошгүй асуудлуудад голлон чиглэж ирсний нэг нь сонгогчдын нэрийн жагсаалт юм. ННФ-аас эрхлэн гаргадаг “Чухал сэдэв”-ийн 2023 оны 2-р сарын дугаарт “Сонгогчдын нэрийн жагсаалтын хяналт, ил тод байдал” сэдвээр иргэний нийгэм, сонгуулийн байгууллага, намууд, бусад оролцогч талуудын хэлэлцсэн саналуудыг эмхэтгэн нийтэлж, сонирхогч талуудад түгээв.


<https://forum.mn/product/262833>

Түүнчлэн СЕХ-ны бие даасан байдлыг бэхжүүлэх асуудлаар ННФ-ын дэмжлэгээр “Оюуны-Инноваци” ТББ-ын гүйцэтгэсэн судалгааны явцын үр дүнг хэлэлцэх, бодлогын зохистой шийдлийн талаар эрх зүйч, судлаачид, иргэний нийгмийнхний саналыг сонсох зорилго бүхий уулзалтыг түс ТББ-тай хамтран зохион байгууллаа. Энэхүү уулзалтад судлаачид, иргэний нийгмийн төлөөлөөс гадна СЕХ-ны Мэдээлэл, судалгаа, арга зүйн хэлтсийн төлөөлөл оролцон бодлогын шийдлийн хувилбар, байр сууриа мөн танилцуулсан юм.



<https://forum.mn/product/370618>

Үндсэн хуулийн өөрчлөлтөд туссан сонгуулийн холимог тогтолцооны талаар онол, практикийн иж бүрэн мэдээллийг бодлогын үйл явцад оролцогч талуудад өгөх зорилгоор “Сонгуулийн холимог тогтолцоо: Онол, практик” сургалтыг Ардчилал, сонгуулийг дэмжих олон улсын хүрээлэн (АСДОУХ)- тэй хамтран зохион байгуулав. 2023 оны 3-р сарын 24-өөс 25-ны өдрүүдэд болсон уг сургалтад УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, парламентад суудал бүхий намууд, иргэний нийгмийн төлөөлөл, эрдэмтэн судлаачдаас бүрдсэн 37 оролцогч оролцож, сонгуулийн холимог тогтолцооны олон янз хувилбар, хувь тэнцүүлэх тогтолцооны нэр дэвшигчдийн нээлттэй болон хаалттай жагсаалт, намын жагсаалтаас суудал хуваарилах томьёоны хувилбарууд, бусад улсын туршлага гэх мэт асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэл авлаа.



АСДОУХ-ийн ахлах зөвлөх Андрю Эллис “Сонгуулийн холимог тогтолцоо: Онол, практик” сургалтын үеэр. 2023 оны 3-р сарын 24

Сургалтыг АСДОУХ –ийн ахлах зөвлөх Андрю Эллис удирдан явуулсан бөгөөд тэрээр сонгуулийн тогтолцооны асуудлаар олон улсын түвшинд өнөөг хүртэл гол эх сурвалж болон хэрэглэгдэж буй сурах бичгийн зохиолчдын нэг юм. Монгол Улсын өмнөх сонгуулиудын үр дүнд үндэслэсэн сонгуулийн холимог тогтолцооны загварчлалыг тусгайлан боловсруулж танилцуулсан нь чухал ач холбогдолтой байсныг оролцогчид сургалтын явцад дурдаж байв. Сургалт нь хуулийн төслийг боловсруулах ажил ид өрнөж байх явцтай давхацсан бөгөөд парламентаас төлөөлөл болж оролцогчдын хувьд сургалтаас олж авсан мэдлэг нь хуулийн төслийг боловсруулах явцад чухал эх сурвалж болсныг онцолж байв. Уг сургалтын дараа 2023 оны 3-р сарын 27-ны өдөр мөн олон улсын мэргэжилтнүүдийг оролцуулан олон нийтийн дүнд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгууллаа.



Дээрхээс гадна 2023 оны 6-р сарын 7-нд Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн үйл явц, сонгуулийн хуулийг сайжруулах асуудлаар хуульчидтай санал солилцох уулзалт зохион байгуулав. Уулзалтын үеэр УИХ-аар хэлэлцэж эхлээд буй Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд улс төрийн намуудтай холбоотой тулгамдсан асуудлуудыг ямар хүрээнд шийдвэрлэхээр тусгасан болон олон улсын холбогдох стандарт, зарчмуудад нийцэх байдлын талаар хуульчдад мэдээлэл өгч хэлэлцүүлэв. Түүнчлэн өнөөг хүртэл

сонгуулийн хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд дорвитой шийдэгдэхгүй явж ирсэн санал худалдан авах үзэгдлийг хуулийн хүрээнд хэрхэн зохицуулж, тэмцэх талаар санал солилцсон юм.

Уулзалтын үеэр Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний гишүүн “Бодлогод залуусын хяналт” ТББ санал худалдан авах үйлдлийг хянах, тэмцэх

зорилгоор хууль тогтоомжид тусаж ирсэн өөрчлөлтүүд, сонгуулийн үеэр гарсан ийм төрлийн зөрчлүүдийг хянаж шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдийг танилцуулж бодлогын зөвлөмж танилцуулсан ба хуульч, өмгөөлөгчдийн зүгээс түүнд шүүмж өгсөн нь зөвлөмжийг боловсронгуй болгоход ач тусгаа өгөх нь дамжиггүй.

Өнөөг хүртэл үйлчилж ирсэн сонгуулийн хууль тогтоомжийн хүрээнд сонгуулийн тойргуудыг байгуулах шийдвэрийг УИХ гаргаж ирсэн. Энэ нь сонгуульд ялалт байгуулсан нам жерримандиринг хийх замаар тэгш бус өрсөлдөөний нөхцөл үүсгэх эрсдэл дагуулдаг тул улс орнууд олон талын оролцоотой, тэнцвэртэй шийдвэр гаргах арга замуудыг хуульчилж мөрдөх нь элбэг. Энэ талаар олон улсын сайн туршлагыг танилцуулах уулзалтыг АСДОУХ-тэй хамтран 2023 оны 3-р сарын 28-нд мөн зохион байгуулсан юм.

Түүнчлэн 2023 оны 10-р сарын 28-29-нд Малайзын нийслэл Куала Лумпур хотноо болсон Энэтхэг, Индонез, Монгол, Малайз, Шри Ланка, Филиппин, Австрали, Бутан зэрэг улсын сонгуулийн хороод, мэргэжилтнүүд оролцсон бүсийн хэмжээний дугуй ширээний хэлэлцүүлэгт дээрх асуудлаар илтгэл тавин хэлэлцүүлж, сонгуулийн тойрог тогтооход бүсийн хэмжээнд баримтлах стандартуудыг боловсруулахад олон улсын мэргэжилтнүүдтэй хамтран

ажиллалаа (Тус дугуй ширээний хэлэлцүүлгээс гарсан сонгуулийн тойрог байгуулахад баримтлах зарчим, стандартуудыг агуулсан Куала Лумпурын тунхаглалыг дараах холбоосоос үзнэ үү: <https://anfrel.org/regional-roundtable-concluded-with-the-kuala-lumpur-declaration-on-apportionment-and-boundary-delimitation/>). Цаашид сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход холбогдох эрх зүйн баримт бичиг, тэдгээрт туссан сонгуулийн тэгш эрхийн зарчимд үндэслэн олон улсад хэрэгжиж буй сайн туршлагыг тусган боловсруулсан дээрх стандартууд нь чухал эх сурвалж болно гэж найдаж байна.

Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, судалгаа, арга зүйн хэлтэстэй хамтран УИХ-ын сонгуулийн хуульд шинээр туссан онцлог зохицуулалтыг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн редакторуудад танилцуулах уулзалтыг 2023 оны 7-р сарын 6-нд зохион байгуулав. Уулзалтад Сонгуулийн ерөнхий хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ оролцож сонгуулийн шинэ тогтолцооны талаарх нарийвчилсан зохицуулалтууд, гадаадад оршин суугаа сонгогчдын бүртгэлийг сайжруулах, санал хураах зохицуулалт, сонгогчдын бүртгэлд тавих хяналт, ил тод байдал зэргийг хэрхэн сайжруулахаар тусгасан талаар танилцуулж сэтгүүлчдийн асуултад дэлгэрэнгүй хариулт өглөө.

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛД ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

УИХ-аас 2023 оны 7-р сарын 4-нд Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлав.

байгууллагуудтай хамтран үе шаттай зохион байгуулж ажиллав. Төслийг боловсруулах үйл явцын талаар сэтгүүлчид, иргэний нийгмийн төлөөлөл, бусад оролцогч талуудад танилцуулах уулзалтыг хоёр ч удаа амжилттай зохион байгуулж, багагүй хувь нэмэр орууллаа.

ННФ-ын зүгээс хуулийн төслийн дэд ажлын хэсэгт орж ажиллахын сацуу төсөлд туссан өөрчлөлтүүд, тэдгээрийн үндэслэл, улс төрийн намтай холбоотой харилцааг хуулиар зохицуулах олон улсын стандарт, сайн туршлагын талаар оролцогч талуудад танилцуулах ажлыг эрдэмтэн судлаачид, дотоодын болон олон улсын

Үүнээс гадна 2023 оны 5-р сарын 31-нд зохион байгуулсан “Улс төрийн намын шинэчлэлийг урагшлуулахад иргэдийн оролцоо” сэдэвт хэлэлцүүлэгт гол илтгэгчээр уригдаж, “Улс төрийн намын тухай хуулийн төслийг боловсруулах үйл явц, улс төрийн намтай холбоотой

онцлох зохицуулалтууд” сэдвээр хот, хөдөөгийн 50 орчим оролцогчид мэдээлэл өгч, хэлэлцүүлсэн юм.

Түүнчлэн Лондон хотноо байрлах Ардчиллын төлөөх Вестминстерийн сангаас 2023 оны 5-р сарын 22-нд улс төрийн нам судлаач, эрдэмтдийн дунд зохион байгуулсан цахим семинарт оролцож “Party Assistance in a Political Context Dominated by a Post-communist Party: The Mongolian Case” сэдвээр илтгэл тавьж, хуулийн төслийн зарим асуудлаар олон улсын мэргэжилтнүүдийн саналыг сонслоо.

УИХ-аас шинэчлэн баталсан Улс төрийн намын тухай хуульд улс төрийн санхүүжилтийн хяналт, ил тод байдлыг

сайжруулах асуудлаар нарийвчилсан зохицуулалтууд тусаж, намүүд санхүүгийн тайлангаа хэзээ, ямар хэлбэрээр олон нийтэд ил тод танилцуулах, төрийн зүгээс хэрхэн хяналт тавих, хууль зөрчсөн нөхцөлд ямар хариуцлага хүлээлгэх зэрэг асуудлыг тусгасан нь ННФ болон бусад иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс гаргаж ирсэн зөвлөмжийн үзэл санаанд нийцэж буй юм. Цаашид хуулийн хэрэгжилтийг хангахад иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран мониторинг хийх, СЕХ болон бусад оролцогч талуудад шаардлагатай техникийн туслалцаа үзүүлэх зэрэг ажлуудыг шат дараатай зохион байгуулах төлөвлөгөөтэй байна.

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХҮРЭЭНД

Үндсэн хуулийн хүрээнд эрчимтэй яригдаж эхэлсэн нэг асуудал нь Үндсэн хуульд ардчиллын тулгуур институци болох Үндсэн хуулийн цэцийн шинэчлэлийг хөндсөн явдал байлаа. Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг 1992 онд баталсан бол Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийг 1997 онд баталснаас хойш дорвитой өөрчлөлт тусалгүй өнөөг хүрчээ. Сүүлийн жилүүдэд олон нийтийн зүгээс Цэцийн бүрэлдэхүүний хараат бус байдлыг нэмэгдүүлэхийг шаардахын сацуу Цэцийн гишүүдийг сонгож, томилох процессыг ил тод, боловсронгуй болгох, Цэцийн гишүүнд тавигдах ёс зүйн болон мэргэжлийн шалгуурыг нарийвчлах шаардлага буйг онцлох болсон юм.

ННФ-ын зүгээс энэ асуудлаарх бодлогын мэтгэлцээнийг бүтээлч байдлаар өрнөхөд мэдээлэл болгох үүднээс Үндсэн хуулийн шүүхийн эрх зүйн олон улсын түршлагыг нэгтгэсэн “Үндсэн хуулийн шүүхийн талаарх венецийн комиссын санал, тайлан, судалгаануудын эмхэтгэл” бүтээлийг МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнтэй хамтран Монгол хэлнээ хөрвүүлээд байна.

(https://cli.num.edu.mn/content/Constitutional%20Court_final.pdf)

Түүнчлэн Үндсэн хуулийн шүүхийн бие даасан байдал болон Үндсэн хуулийн процессын эрх зүйн асуудлаар бус нутагтаа жишээ болохуйц сайн түршлагад тооцогддог Солонгос улсын Үндсэн хуулийн шүүхээс түршлага судлах ажлыг Үндсэн хуулийн цэц болон УИХ-тай хамтран 2023 оны 4 сард зохион байгууллаа. Энэхүү үйл ажиллагаанд УИХ-аас хуулийн ажлын хэсгийг ахалж буй УИХ-ын гишүүд, судлаачид болон иргэний нийгмийн төлөөллүүд оролцсон юм.

Түршлага судлах явцад тус улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч Киён Ким, Үндсэн хуулийн шүүхийн дэд нарийн бичгийн дарга Чан Вон Ким тэргүүтэй хүмүүс Солонгосын Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүнийг сонгох, маргаан шийдвэрлэх процесс, үүнд ялангуяа үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэх процессын талаар танилцуулж, ажлын хэсгийн гишүүдтэй санал солилцов.

Дээрх институцийн талаар бие даасан хуульч, судлаачдын байр суурийг сонсох зорилгоор Сөүлийн үндэсний их сургууль (СҮИС)-ийн Хуулийн сургууль, Нийтийн эрх ашиг, хуулийн клиник сургалтын төвийн профессоруудтай үулзалт хийж, сонирхсон асуултуудын хүрээнд илэн

далангүй хэлэлцүүлэг өрнүүлснээс гадна Үндсэн хуулийн шүүх дээр үндсэн эрхийн маргаанаар мэргэшсэн сайн дурын өмгөөлөгчдийн байгууллага болох “Ардчилсан нийгмийн төлөөх өмгөөлөл” (MINBYUN) ТББ-ын ахмад болон залуу үеийн төлөөлөл болсон өмгөөлөгчидтэй үулзалт, хэлэлцүүлэг өрнүүлэв.

УИХ-аас боловсруулсан Монгол Улсын Цэцийн тухай хууль болон Монгол Улсын Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслүүд нь олон улсын сайн түршлага болон стандартуудад хэрхэн нийцэж буй талаар АСДОУХ-ийн үндсэн хуулийн мэргэжилтнүүдийн саналыг авч хуулийн ажлын хэсэгт танилцуулах ажлыг мөн зохион байгуулав.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН АСУУДЛААР

Ардчиллын институцийг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд анхаардаг нэг чухал асуудал нь иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх буюу нийгэмд өрнөж буй бодлогын болон бусад асуудлаарх мэтгэлцээнд саад тотгоргүй оролцох, байр сууриа илэрхийлэх, мэдээллийн ил тод байдал, чөлөөт урсгалыг дэмжихэд чиглэдэг билээ. Энэ хүрээнд “Глоб Интернэшнл төв”, “Бодлогод залуусын хяналт”, “Цогц Хөгжлийн Үндэсний төв”, “Тунгаахуй өгөгдлийн урлан” зэрэг ТББ-уудтай хамтран хэлэлцүүлгүүд өрнүүлэх, зөвлөмж гаргах, бодлогын өөрчлөлтүүдийг ажиглан, дэвшилттэй санаачилга хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх байдлаар хамтран ажиллаж ирлээ.

2023 онд авлига, ашиг сонирхлын зөрчлийн хэд хэдэн томоохон хэрэг илэрсэн бөгөөд түгээмэл ажиглагдсан асуудал нь хууль бус шийдвэрийг төрийн нууцад хамруулах замаар халхавчлах явдал байлаа. Нууцтай холбоотой хууль тогтоомжид хийдэл байгааг илэрхийлсэн дээрх тохиолдлуудад дүн шинжилгээ хийж, мэдээлэл нууцалж буй байдлыг нарийвчлан судлах, тодорхой санал боловсруулах, талуудыг оролцуулсан шүүмжлэлт хэлэлцүүлэг өрнүүлэх хэрэгцээ тулгарч байна.

Үүнтэй холбоотой Тендерийн хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлууд буюу “Төрийн нууц ба тендер” хэлэлцүүлгийг 2023 оны 10-р сарын 2-нд зохион байгууллаа. 2005 онд батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн үйлчлэлээс гарах, гэрээ

шууд байгуулах аргыг хэрэглэхтэй холбоотойгоор нийт 18 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг УИХ-аас баталсан бөгөөд энэ арга сүүлийн жилүүдэд улам бүр газар авч, бусад хууль тогтоомжийг дагалдуулан “тендерийн” гэж нэрлэгдэж заншсан хуулийн үйлчлэлд хамаарахгүй байх заалт нэмэх, эсхүл шууд гэрээ байгуулах зэргээр хуулийн цоорхойг нэмэгдүүлэх болсон байна. УИХ-аас 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийг шинэчлэн баталсан юм. Хуульд төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх улсын чанартай авто замын болон нийслэлийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх нийслэл хотын хот тохижилт, авто замын засвар, арчилгаа, хог хаягдалтай холбоотой ажил, үйлчилгээг хуулийн үйлчлэлд хамааруулахаар заасан бөгөөд хоёр удаа амжилтгүй зохион байгуулсан тендер шалгаруулалт болон тодорхой салбарын худалдан авах ажиллагааг онцлон шууд гэрээ байгуулдаг өмнөх цоорхойг нөхсөн нь мөн анхаарал татав. Тус шинэчилсэн хуулийг хэрэгжүүлэхдээ тууштай байж, явцад нь “цоорхой” нэмэн баталж тарамдуулдаг байдлыг гярхай хянан, анхаарах шаардлагатай болохыг хэлэлцүүлэгт оролцогчид онцлон тэмдэглэсэн болно.

“Глоб Интернэшнл төв” ТББ нь Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр 2022 оны 9 сарын 1-ээс 11 сарын 15-ны хугацаанд 2021 онд шинээр батлагдсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтэд мониторинг хийсэн юм.



Энэхүү мониторингийн үр дүнгийн талаар 2023 оны 1-р сарын 26-нд болсон “Иргэдийн мэдэх эрх хангагдаж байна уу?” сэдэвт хэлэлцүүлгийн үеэр танилцуулав. Мониторингийн дүнгээс товч танилцуулбал, судалгаанд хамрагдсан иргэдийн 63 хувь нь төрийн байгууллагаас хүссэн мэдээллээ огт авч чаддаггүй гэсэн байна. Мөн хууль хэрэгжүүлж буй төрийн албан хаагчдын 66 хувь нь тус хуулийг хэрэгжүүлэх талаар хангалттай мэдлэггүй гэсэн үр дүн гарчээ. Судалгаанд хамрагдсан мэдээлэл хариуцагч 38 байгууллагын хуульд нээлттэй байхаар заасан 44 төрлийн мэдээлэлд мониторинг хийхэд 58.5 хувийг нь огт ил болгоогүй байна. Мөн мэдээлэл хариуцагч 51 байгууллагаас амаар, бичгээр болон цахимаар мэдээлэл хүсэхэд 47 хувь нь огт хариу өгөөгүй байна.

<https://forum.mn/post/126099>

Хэлэлцүүлэгт Цахим хөгжил харилцаа холбооны яам болон Хүний Эрхийн үндэсний комисс, Монголын Эмнести Интернэшнл байгууллагын төлөөллүүд оролцон хуулийн хүрээнд иргэдийн мэдэх эрхийг хангах чиглэлээр өөрсдийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, байр суурийг илэрхийлсэн илтгэлүүд хэлэлцүүлэв. Түүнчлэн Хууль зүй дотоод хэргийн яам, Авлигатай тэмцэх газрын төлөөллүүд “Төрийн мэдээллийн ил тод байдал сайжирсан уу?” сэдэвчилсэн хэлэлцүүлгүүдийг удирдаж, өөрсдийн байр сууриа илэрхийлэн, оролцогчид болон сэтгүүлчдийн асуултад хариуллаа.

2023 оны 12-р сарын 20-нд төсөв, ашигт малтмал зэрэг тодорхой асуудлаар мэдээлэл авахад тулгарч буй асуудлыг тодруулах зорилгоор мөн салбарын мэргэжилтнүүдийг оролцуулсан уулзалт зохион байгуулсан ба цаашид мэдээллийн ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн шүүмжлэлт хэлэлцүүлгүүдийг байнга өрнүүлж, гарсан санал зөвлөмжийг олон нийт болон бодлого боловсруулагчдад хүргэхэд анхаарч ажиллана.



ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам

“Төсвийн мэдээллийг нээлттэй өгөгдлийн шаардлагад нийцүүлэх, тусгай сангуудын зарцуулалт, төрийн өмчит компаниудын худалдан авалтад холбогдох шийдвэрийг ил тод болгох зохицуулалтыг бүрдүүлэх, аймаг, нийслэлийн төсвийн төлөвлөлтийн баримт бичиг, зарцуулалтад холбогдох шийдвэрийн ил тод байдлыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

Төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн үр ашиг, эрэмбийн мэдээлэл, төсвийн тодотгол хийгдэх тохиолдолд хөрөнгө оруулалтын нэмэгдсэн, хасагдсан төслүүд болон санхүүжилтийн дүнд нь өөрчлөлт орсон төслүүдийг шүүд харах боломжтой байдлаар ил болгох эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй юм.”

“Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба мэдэх эрхийн хэрэгжилт-2023” хэлэлцүүлэг 2023 оны 12 дугаар сарын 20.



ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Эрдэнэчимэг

“Төрийн нээлттэй өгөгдлийн сангуудын “хаалттай” байдлыг арилгахгүйгээр авлигаас ангижирч чадахгүй. Жишээ нь, эцсийн өмчлөгч, шилэн данс, худалдан авах ажиллагаа, ХАСХОМ зэрэг мэдээллийн сангууд ихэнх нь машинаар унших боломжгүй, шалган баталгаажуулалт хийгддэггүйгээс бүрэн бус, алдаа ихтэй, хоорондоо холбоогүй учраас энгийн хүн тэр бүр ашиглах боломжгүй байдаг.”

“Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба мэдэх эрхийн хэрэгжилт-2023” хэлэлцүүлэг 2023 оны 12 дугаар сарын 20.

“Нээлттэй засаглалыг бэхжүүлэхэд нээлттэй өгөгдлийг ашиглах нь” сэдэвт иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан сургалтыг 2023 оны 1 сарын 31-нд зохион байгуулахад нь “Тунгаахуй өгөгдлийн урлан”, “Бодлогод залуусын хяналт”, “ Глоб Интернэшнл төв” ТББ-уудад дэмжлэг үзүүлж хамтран ажиллав. Төрд цугларсан суурь өгөгдлүүд нээлттэй болсноор олон нийт төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, оролцоог хангах, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих, улмаар ил тод, нээлттэй засаглалыг бэхжүүлэхэд чухал нөлөөтэй.

Сургалтаар 2022 оны 5 дугаар сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд

түссэн нээлттэй өгөгдлийн талаарх зохицуулалтууд, холбогдох журам, ИНБ-уудын өгөгдлийн хэрэглээ ба үр чадвар, шаардлагатай өгөгдлийг хайж олох, ашиглахад тулгарч буй асуудлууд, засаглалыг бэхжүүлэхэд нээлттэй өгөгдлийг ашиглах боломж зэрэг сэдвээр мэдээлэл өгөв.

Дээрхээс гадна нийтийн эрх ашгийг хамгаалах, төрийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд нээлттэй өгөгдлийг хэрхэн ашиглах талаар иргэний нийгэмд сурталчилж таниулах зорилгын хүрээнд “Дата эрх чөлөө” үзэсгэлэнг “Сонгуулийн хяналт” сэдвээр 12-р сарын 6-аас 10-ны өдрүүдэд зохион байгуулахад “Бодлогод залуусын хяналт” ТББ-д дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа.



“Дата эрх чөлөө” үзэсгэлэн. 12-р сарын 6. Blue mon үзэсгэлэнгийн танхим

Үзэсгэлэнг зохион байгуулахад Авлигатай тэмцэх газар, Сонгуулийн ерөнхий хороо болон “Цогц хөгжлийн үндэсний төв”, “Тунгаахуй өгөгдлийн үрлан” ТББ-үүд хамтран оролцов. 2023 онд батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-т улс төрийн авлигыг 2030 он гэхэд дорвитой бууруулах, улс төрийн санхүүжилт, тайлагналт, хяналтын үндэсний тогтолцоог бэхжүүлэх, санал худалдан авахыг хориглох эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилт дэвшүүлснээрээ онцлог юм.

Үзэсгэлэнгийн хүрээнд “Бодлогод залуусын хяналт” ТББ-ын 2020 оны УИХ, 2021 оны ерөнхийлөгчийн сонгуульд

өрсөлдсөн нам эвсэл, нэр дэвшигчдийн зардлын анхдагч тайлангийн нэгтгэсэн дүн, “Цогц хөгжлийн үндэсний төв” ТББ-аас 2020-2024 оны УИХ-ын гишүүдийн ирцийн мэдээлэл болон хууль батлах үйл явц дахь ашиг сонирхлын зөрчлийг хянах асуудлаар хийсэн шинжилгээг танилцуулав. Түүнчлэн, Сонгуулийн ерөнхий хорооны зүгээс өнгөрсөн сонгуулиудын үр дүн, мэдээллийг нээлттэй өгөгдөл болгон, олон нийтэд танилцуулсан юм. Үзэсгэлэнгийн явцад эдгээр асуудлаар судалгаа хийдэг судлаачид, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулсан уулзалт, хэлэлцүүлгүүд мөн болсон юм.

ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛД

Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулав.

Захиргааны ерөнхий хууль батлагдаж, хэрэгжиж эхэлснээс хойш уг хуульд туссан нэмэлт, өөрчлөлтүүдтэй харьцуулахад энэ удаагийн нэмэлт, өөрчлөлт нэлээд өргөн цар хүрээг хамарснаараа онцлог байв. ЗЕХ-д нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дагалдуулан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зарчмын шинжтэй нэмэлт, өөрчлөлтүүд оруулснаас гадна Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд мөн нэмэлт, өөрчлөлт оруулсан юм.

Эдгээр нэмэлт, өөрчлөлтийн зэрэг болон сөрөг үр дагавар, тухайлбал Засгийн газрын улс төрийн шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор гаргаснаас бусад шийдвэртэй холбоотой шийдвэр нь Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл үүсгэхэд хүндрэл үүсэх эсэх талаар мэргэжилтнүүдийн дүн шинжилгээг иргэний нийгмийн байгууллагууд болон ашиг, сонирхол нь хөндөгдсөн бусад талуудад хүргэх зорилгоор “Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эргэн тойронд сэдэвт” видео подкастыг “Оюуны-Инноваци” ТББ-тай хамтран, бэлтгэж хүргэлээ.

<https://www.youtube.com/watch?v=3j447pvrdr1>

Подкастын зочноор МХХ-ны Захиргааны эрх зүйн хорооны Тэргүүн, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Мөнх-Эрдэнэ оролцож мэдээлэл өгөв.

ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДЛААРХ НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ

УИХ-аас 2023 оны 1-р сарын 23-ны өдөр “Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль” (цаашид Олон нийтийн сүлжээний хууль гэх)-ийг батлав.

Хуулийг өргөн барьснаас хойш гуравхан хоногт хэлэлцэн баталснаар “Ковид”-ын хуулийг яаравчлан баталснаас ч ахархан хугацаа зарцуулсан нь анхаарал татсан бөгөөд хуулийн зарим зохицуулалт нь иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг дүр зоргоороо хүмий

эрсдэл бий болгож буйг иргэний нийгмийн зүгээс хүчтэй шүүмжилсэн юм. Олон нийтийн сүлжээний хууль нь 2023 оны 2-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэх байсан боловч Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх 2023 оны 2-р сарын 27-нд хориг тавьсан бөгөөд улмаар УИХ хоригийг хүлээн авсан билээ. Ерөнхийлөгчийн хоригт дээрх хуулийг боловсруулж гаргах үйл явцад “олон нийтийн оролцоог хангаагүй, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдийн саналыг аваагүй” болохыг тэмдэглэжээ.



ННФ-ын зүгээс олон нийтийн сүлжээтэй холбоотой харилцаанд үйлчилж буй олон улсын эрх зүй, хүний эрхийн чиглэлээр мэргэшсэн ICNL буюу Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн олон улсын төв (АТХЭОУТ)-ийн эрх зүйчидтэй хамтран дээрх хуульд шүүмж бэлтгэн олон нийтийн хүртээл болгов.

Дээрх байгууллагын Хуулийн ахлах зөвлөх Жули Хантер 2023 оны 6-р сард Монгол Улсад ирж ажилласныг тохиолдуулан “Нийгмийн сүлжээн дэх хүний эрхийн асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг үг асуудлаар идэвхтэй ажиллаж буй иргэний нийгмийн байгууллагууд болох “Монголын эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв” (МЭССТ) болон “Цогц хөгжлийн үндэсний төв” ТББ-уудтай хамтран зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн эхэнд 2020 оны УИХ-ын болон 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр олон нийтийн сүлжээнд хийсэн мониторингийн үр дүн, тоо баримтад үндэслэн “Нийгмийн сүлжээн дэх хүний эрхийн асуудлууд” сэдвээр МЭССТ-ийн гүйцэтгэх захирал Ц.Тамир мэдээлэл өгсөн ба Жули Хантер “Цахим орчныг зохицуулах оролдлогууд, сургамж, олон улсын сайн туршлага” сэдвээр илтгэл тавьж Монгол Улсад тулгамдаж байгаатай ижил төстэй асуудлыг бусад улсуудад хэрхэн шийдвэрлэж буй талаар ярилцлаа.

<https://forum.mn/product/265468>



“Цогц Хөгжлийн Үндэсний Төв” ТББ-ын гүйцэтгэх захирал М.Энхбадрал:

Эстони улсын нийслэл Таллин хотод болсон Нээлттэй засгийн түншлэлийн дээд хэмжээний уулзалтад оролцох явцад бусад улсын оролцогчидтой танилцаж, туршлага судалсан нь бидний хувьд чухал боломжуудыг нээж өглөө. Энэ уулзалтын үеэр парламентын ил тод байдлыг сайжруулах чиглэлээр ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй бусад орны байгууллагуудын төлөөлөлтэй уулзаж ярилцан, харилцаа холбоо тогтоосны үр дүнд “Цогц Хөгжлийн Үндэсний Төв” ТББ Парламентын ил тод байдлын Азийн сүлжээнд Монгол Улсыг төлөөлсөн гишүүн болоод байна.

Энэ нь ардчиллыг бэхжүүлэх, парламентын хяналт, мониторингийн чиглэлээр ажилладаг БНСУ, Тайланд, Шри-Ланка, Филиппин, Тайван, Индонези, Камбож, Монгол, Мьянмар гэх мэт Азийн 10 орчим улсын төлөөллийг нэгтгэсэн Олон Улсын шинэ сүлжээ юм. Үг сүлжээний анхны уулзалт 2023 оны 11-р сард Австрали улсын Мелбурнийн их сургуульд болсон бөгөөд үг уулзалтад манай байгууллага уригдан оролцлоо.

Бидэнтэй ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай харилцан туршлага солилцох, хамтран ажиллах боломж ийнхүү нээгдсэн нь манай байгууллагын цаашдын үйл ажиллагаанд ихээхэн ач түс өгөх нь дамжиггүй. Энэхүү боломжийг нээж өгсөн Нээлттэй нийгэм форумд гүн талархал илэрхийлье.

Нээлттэй засгийн түншлэлийн 2023 оны их хурал нь цахим эрин дэх нээлттэй засаг буюу технологийн дэвшлийг ашиглан засаглал, бодлого боловсруулах үйл явцыг ил тод болгох, ардчиллыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах асуудлыг онцолсон юм. Эстони Улс нь цахим засаглал, иргэний нийгмийн идэвхтэй оролцооны арвин туршлага бүхий орон билээ. ННФ-аас энэхүү үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулах болсон зорилго нь зөвхөн Эстони Улсын туршлагаас судлаад зогсохгүй бүс нутаг болон олон улсад засаглалын чиглэлээр ижил төстэй зорилго тавин ажиллаж буй байгууллагуудтай харилцаа тогтоож, сүлжээгээ өргөжүүлэх, улмаар ардчилал, сайн засаглалтай холбоотой олон улсад өрнөж буй хэлэлцүүлгүүд, үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, хувь нэмрээ оруулах бололцоог нь нээхэд чиглэж байв.



Нээлттэй засгийн түншлэлийн дээд хэмжээний уулзалтын үеэр. Эстони Улс. Таллин хот. 2023.11.7

Дээрхээс гадна иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжих ажлын хүрээнд Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээнээс 2024 оны УИХ-ын сонгуульд бие даасан хяналт тавих иргэний нийгмийн ажиглагчдын үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Ардчиллын манаанд” хандивын үйл ажиллагааг 2023 оны 11-р сарын 15-ны өдөр “Бодлогод залуусын хяналт” ТББ-тай хамтран зохион байгууллаа.

Түүнчлэн Төрийн бус байгууллагын тухай хуулийг орлох Холбоо, сангийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулах үйл явцад багагүй хөндөгдсөн “Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)–ын зөвлөмж, түүнийг тойрсон зарим асуудал, ойлголтын зөрөөний талаар иргэний нийгмийн төлөөлөлд мэдээлэл өгөх уулзалт”-ыг Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн (IRI), Ашгийн төлөө бус хуулийн олон улсын төвтэй хамтран зохион байгуулав. Үг үйл ажиллагаанд Европ дахь АТХЭОУТ-ийн мэргэжилтнүүд оролцож ФАТФ –ын зөвлөмжийн үндэслэл болох эх сурвалжууд, түүнийг боловсруулах үйл явц, үүнд иргэний нийгмийн оролцох боломж, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд гарч болзошгүй сөрөг үр дагаврыг хэрхэн бууруулах талаар үнэтэй мэдээлэл өглөө.

Монгол Улс дэлхийн 70 гаруй орон нийлсэн Нээлттэй засгийн түншлэлд нэгдээд 10 жил болж байгаа бөгөөд 2024-2027 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний

төслийг олон нийт, иргэний нийгмийн оролцоотой боловсруулан баталж, олон улсын өмнө амлалт өгөөд буй. Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөнд авлигатай тэмцэх, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, үүнд ялангуяа нийтийн мэдээллийг нээлттэй өгөгдөл болгож хүртээмжийг сайжруулах, улс төрийн санхүүжилтийн хяналтыг чангатгах гэх мэт ННФ-ын үйл ажиллагааныхаа хүрээнд анхаарч буй асуудлууд туссан юм.

Нээлттэй засгийн түншлэлээс төр, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан тогтмол зохион байгуулдаг дээд хэмжээний уулзалт Эстони улсын Таллин хотноо 2023 оны 9-р сарын 6-7-ны өдрүүдэд болсон бөгөөд энэхүү үйл ажиллагаанд сайн засаглалын чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг “Бодлогод залуусын хяналт” ТББ-ын гүйцэтгэх захирал Ц.Мандхайхатан, “Цогц хөгжлийн үндэсний төв” ТББ-ын гүйцэтгэх захирал М.Энхбадрал нарыг дэмжин оролцууллаа.



Ц.Мандхайхатан “Бодлогод залуусын хяналт” ТББ-ын тэргүүн. “Ардчиллын манаанд” хандивын үйл ажиллагаа. 2023.11.15

Өнгөрсөн хугацаанд ННФ-ын зүгээс ардчиллын гол үйл явц болох сонгуулийн үйл явцыг боловсронгуй болгох, будлиан зөрчил гарахаас сэргийлэх, улмаар сонгуульд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд иргэний нийгмийн хяналт тавих чадавхыг бэхжүүлэх, оролцоог хангах чиглэлд тасралтгүй дэмжлэг үзүүлж ирлээ. Үүний үр дүнд сонгуулийн үйл явцын ил тод байдал, саналын хуудасны хамгаалалт, аюулгүй байдал, сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангах гэх мэт сонгуулийн үйл явцад тулгамдсан асуудлуудыг шийдэж, холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлд чамлахааргүй ахиц дэвшил гарсан юм.



ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОН ЗАЙН ХӨТӨЛБӨР



ИРГЭД, ИНБ-УУДАД ХҮРГЭХ ШИНЭ МЭДЭЭЛЭЛ, ШИНЭЛЭГ УР ЧАДВАР

Иргэний нийгэм нь иргэд, тэдний байгуулсан байгууллага, бүлгүүд нийтийн үйл хэрэгт оролцох талбар, ардчиллын нэг гол институци юм. Иргэний нийгэм нь төрөөс баталсан хууль эрх зүйн орчин, төрийн байгууллагуудын хууль хэрэгжүүлэх түвшний практикаар бий болгож өгсөн орон зайд үйл ажиллагаа явуулдаг тул иргэний нийгмийн энэхүү орон зайг нээлттэй байлгаж, дэмжих нь иргэдийнхээ өмнө хүлээсэн ардчилсан төрийн үүрэг. Идэвхтэй иргэн, иргэний нийгмийн байгууллагууд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэн, нийтлэг зорилтын төлөө эвлэлдэн нэгдэж, шүүмжлэлт дуу хоолойгоо төр, шийдвэр гаргагчдад хүргэхээр цуглах эрх чөлөө хэр хангагдсанаар иргэний нийгмийн орон зай нээлттэй, эсвэл саадтай байгааг хэмжиж болно. Нээлттэй иргэний орон зай нь ардчиллын чанарын үзүүлэлт, ардчилсан нийгмийн дарангуйллаас ялгах хэмжүүрийн нэг юм.

Харамсалтай нь, төр, захиргааны бодлого шийдвэр, үйл ажиллагаа нь ИНБ-уудад ээлгүй болж, иргэний нийгмийн орон зай хумигдах, ардчиллын чанар доройтох үйл явц дэлхий нийтээр үргэлжилсээр байна [СИВИКУС (2023). Эрхийн хамгаалалт бүүрсан нь: Иргэний нийгмийн орон зай хумигдах хандлага. Түүхэн дүн шинжилгээ. <https://monitor.civicus.org/rights-reversed-2019-to-2023/>].

ННФ нь иргэний нийгмийн идэвхтэн зүтгэлтэн, олон нийтийн оролцоог хөхиүлэн дэмжиж, мэдлэг мэдээллээр хангахын зэрэгцээ мэргэжлийн үйл ажиллагаагаараа иргэний эрх, оролцоог бодитоор дэмжиж чадах мэргэжилтнүүдийг чадавхжуулахад анхааран ажиллаж байна. 2023 онд ННФ-ын Иргэний нийгмийн орон зайн хөтөлбөр нь ИНБ-уудыг бүтээлч үр чадвар, шинэ мэдээллээр хангах, олон нийтийн мэдээллийн

боловсролыг дэмжих, хуульч болон сэтгүүлчдийг иргэний оролцооны асуудалд татан оролцуулахад төвлөрч ажиллалаа.

Иргэний нийгмийн орон зайг бэхжүүлэх нэг чухал хүчин зүйл бол ИНБ-уудыг олон нийт ойлгож дэмжих явдал юм. ТББ-уудад мэдлэг чадавхаа бэхжүүлэх, шинэчлэх, шинэ үр чадвар олж авах боломж нэн хязгаарлагдмал



2016 оны УИХ-ын сонгуулийн иргэний нийгмийн ажиглагчид. 2016.07.1

байна. Улмаар ННФ нь ТББ-уудад шинэлэг, сонирхолтой арга хэлбэрээр олон нийтэд танигдахад туслах зорилгоор цуврал сургалт хэрэгжүүлээ.

ННФ нь ТББ-уудад бодлогын болон олон нийтийн орчинд илүү танигдаж, бодлогын нөлөөлөл, олон нийтийн боловсролын үйл ажиллагааг илүү үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд нь туслах хэрэгцээ байгааг олж харан, ИНБ-уудад зориулсан сургалт, мэдээллийн цуврал арга

хэмжээ хэрэгжүүлж эхэллээ. 2023 онд “ТББ-ын цахим аюулгүй байдал”, “Нийгмийн сүлжээн дэх мэдээллийг нягтлах замаар хуурамч мэдээллийг таних нь”, “Бодлогын судалгааны арга зүйг танилцуулах нь” зэрэг сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 120 хүнийг хамруулав. Цаашид цуврал сургалтын сэдэв, агуулга нэмэгдэн, ИНБ-ууд сонгох, бие даан суралцах боломжтой болох юм.



«Цахим аюулгүй байдал» сургалт. 2023 оны 2-р сарын 2. ННФ-ын хурлын танхим.

Сүүлийн 10 гаруй жилд, ялангуяа 2017 оноос хойш дэлхий нийтээр иргэний нийгмийн орон зайг хумих, хязгаарлах үйл явц үргэлжилж байгааг дэлхийн нэр хүндтэй судалгааны эх сурвалжууд баримтжуулсаар байна [V-Dem, 2023 Democracy report. Defiance in the Face of Autocratization]. Англи хэл дээр гардаг эдгээр судалгааг Монголын уншигч, идэвхтнүүдэд илүү таниулах, хүргэх зорилгоор ННФ нь иргэний нийгмийн орон зай, ардчиллын тогтмол давтамжтай үнэлгээ, рейтинг, индексүүдийн тойм тайланг бэлдэн гаргаж эхэллээ. СИВИКУС олон улсын байгууллагын “Дэлхий нийтийн иргэний нийгмийн төлөв байдлын 2023 оны тайлан” (<https://forum.mn/post/134796>)-д Монгол Улсын иргэний нийгмийн орон зай нь 2023 оны байдлаар хумигдсан төлөв байдалтай байна. 2021 онд Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль баталснаар манай улс ийнхүү саадтай ангиллаас дэвшиж, нээлттэй болоход нэг алхам ойртсон юм.

ННФ нь ИНБ-уудыг олон нийт, хандивлагчдад таниулах, ИНБ-уудад мэдээлэл хүргэх, тэдний мэдээллээ нийтэлдэг цахим орон зайг бий болгох зорилгоор www.cso.mn сайтыг ажиллуулж байна. Уг сайтад

ТББ-ууд бүртгүүлэн, үйл ажиллагааны зар, мэдээлэл, судалгааны тайлангаа байршуулах боломжтой бөгөөд энэ нь ялангуяа өөрийн веб сайтгүй ТББ-ууд ажил хэргээ олон нийт, төрийн байгууллага, хандивлагчдад сурталчлахад дэмжлэг болно хэмээн найдаж байна. ННФ нь мөн ТББ-ууд хамрагдах боломжтой бүхий л төрлийн тэтгэлгийн үралдаан, дэмжлэгийн зарыг уг сайтад байршуулж байна. Иймд байгууллагаа www.cso.mn сайтад бүртгүүлэн, даваа гараг бүрт өмнөх долоо хоногт нийтлэгдсэн шинэ мэдээллийн тоймыг цахим шуудангаар хүлээн аваарай.



ИРГЭНИЙ ОРОЛЦООНЫ МЕХАНИЗМУУДЫГ СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХ ТҮНШЛЭЛ

НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ ШҮҮХЭЭР НЭХЭМЖЛЭН ХАМГААЛАХ БУЮУ СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ

ННФ нь нийтийн зөрчигдсөн эрх ашгийг хамгаалан, шүүхэд нэхэмжлэл гаргасан ТББ-уудтай хамтран ажиллаж ирсэн арвин туршлагатай. 2023 онд бид стратегийн өмгөөлөл гэж нэрлэгддэг нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэл гаргаж хамгаалах иргэний оролцооны энэхүү арга механизмыг хуульчид, хуулийн сургуулийн оюутнуудад эзэмшүүлэх төсөл санаачилсан “Хил хязгааргүй хуульчид” ТББ-ыг дэмжиж ажиллалаа.

Тус ТББ нь эрх зүйч оюутан, залуу хуульч, хуулийн фирмийн хуульчдыг нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалах асуудалд анхааруулах, стратегийн өмгөөлөл хийх туршлага суулгах, олон нийтэд нийтийн эрх ашгийн асуудлуудыг таниулахад чиглэсэн “Оюутны

стратегийн өмгөөлөл, нөлөөлөл” төслийг ННФ-ын дэмжлэгтэйгээр 2023 оны 1 сараас нэг жилийн хугацаанд амжилттай хэрэгжүүлээ.

Хууль зүйн хөтөлбөртэй МУИС-ийн Хууль зүйн сургууль, Дотоод хэргийн их сургууль, Билэг, Отгонтэнгэр, Шихихутуг зэрэг 10 их, дээд сургуулийн 600 гаруй оюутанд мэдээлэл өгч, стратегийн өмгөөллийг танилцуулах сургалтуудаар эхэлсэн уг төсөлд 60 гаруй оюутан төслийн санал боловсруулж ирүүлснээс эцсийн шалгаруулалтад 28 оюутны 5 багийн боловсруулсан төсөл шалгарч, 2023 оны 4 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн юм.



«Оюутны стратегийн өмгөөлөл, нөлөөлөл 2023» хөтөлбөрийн нээлт. 1 дүгээр сарын 31

Оюутнууд төслөө боловсруулахдаа стратегийн өмгөөллийн туршлагатай хуульч, ТББ-уудаас агуулга, арга зүйн мэдлэг, туршлагыг нь судалж, сургуулийн болон орон нутгийн удирдлагуудаас тулгамдсан

асуудлуудыг нь сонсож ажиллав. Хуулийн фирмүүд сайн дурын үндсэн дээр оюутны багуудтай хамтран ажиллаж, шүүхэд нэхэмжлэл гаргах, нотлох баримт цуглуулах зэрэг мэргэжлийн процессын хөтөч хийж, чиглүүлсэн юм.

Багийн нэр	Төслийн танилцуулга	Хөтөч хуулийн фирм	Төслийн үр дүн
Альфа баг	“БЗД-ийн 33 дугаар сургуулийн орчмын бүсэд ихээр төвлөрсөн баар, караокед согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгосон Нийслэлийн Засаг даргын шийдвэрийг хүчингүй болгуулах” төсөл	Өмгөөллийн “Фиделитас партнерс” хуулийн фирм	<ul style="list-style-type: none"> - БЗД-т архи, согтууруулах ундаа борлуулах тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдийн тоог гаргуулав - Нийслэлийн засаг даргад урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар гомдол гаргав - Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргав - unuudur.mn сайттай хамтран иргэдэд мэдээлэл хүргэв - Хороон Засаг дарга, сургуулийн захиралд мэдээлэл хүргэв - “Сурагчид сургуулийн ойр орчим дахь караоке, баарны зөвшөөрлийг цуцлахыг хүсэж байна” видео контент хийж, нийгмийн сүлжээ, хорооны фейсбүүк хуудсаар тараасан нь 200,000 хандалт авав.

Виолета баг	“Төрийн байгууллагын үйлчилгээний хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлыг сайжруулах” төсөл	Өмгөөллийн “Эм Жэй Эл атторнейс” ХХН, “Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо” ТББ	<p>Төрийн үйлчилгээ үзүүлж буй байруудыг хүртээмжийн зохих стандартад нийцүүлэх зорилгоор</p> <ul style="list-style-type: none"> - Засгийн газрын 2 дугаар байрны гадна талбайг засаж сайжруулах талаар Эдийн засаг хөгжлийн яаманд; - Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газарт; - Хот байгуулалт, хөгжлийн газарт - Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанд тус тус хүсэлт гаргав. - Чингэлтэй дүүргийн 54 байгууллага, аж ахуйн нэгжид Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн талаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв. - Нийслэлийн ЕБС-ийн сурагчдын дунд “Орчны хүртээмж ба хүний эрх” эсээ, гар зургийн уралдаан зохиов. (Шалгарсан зургийг оруулъя)
-------------	--	--	---

Дипи баг	“Сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрх” төсөл	Өмгөөллийн “Легал Гайд” хуулийн фирм	<p>БШУ-ны Сайдын “Бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах чиглэлд цаашид хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний мэдээлэл, үр дүнгийн тайланг гаргуулах” асуудлаар хуулийн хугацаанд бичгээр хариу өгөхгүй байгаа эс үйлдэхгүйг хууль бус болохыг тогтоож, дурдсан баримт, тайлан, мэдээллийг гаргаж өгөхийг даалгах шаардлага бүхий нэхэмжлэлийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - 29 дүгээр сургуулийн сурагч, төгсөгчидтэй хийсэн цуврал ярилцлага, мэдээллийг нийгмийн сүлжээгээр олон нийтэд түгээв. - 29-р сургуулийн 12-р ангийн сурагчдад хөдөлмөрийн эрх зүйн харилцааны тухай сургалт оров.
----------	--	--------------------------------------	--

Багийн нэр	Төслийн танилцуулга	Хөтөч хуулийн фирм	Төслийн үр дүн
Фемида баг	“Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн сургуулийн өмнөх боловсрол эзэмших эрх” төсөл	“Онч нүүдэл” хуулийн фирм, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо” ТББ	<ul style="list-style-type: none"> - 11 хүүхдийн эцэг эхэд эрх зүйн зөвлөгөө өгөв - МУБИС-ийн Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрт Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхэдтэй ажиллах цогц агуулга бэлдэж өгөв - Ялгаварлан гадуурхалтын улмаас сургуульд хамрагдаж чадахгүй байгаа асуудлыг шийдүүлэх процессыг зурагласан постер бэлдэж, түгээв (Постерын зургийг авъя) - “Аутизмтай хүүхдийн эрх” сэдэвт видео контентыг оюутан залуучуудад түгээв
Даймонд баг	“Хууль бус ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох замаар байгаль орчныг хамгаалах” төсөл	“Хил хязгааргүй алхам” ТББ, Өмгөөллийн “Легал Гайд” хуулийн фирм	Дорноговь аймгийн Хатанбулаг суман дахь хулангийн бэлчээр төдийгүй археологийн олдвортой соёлын өв бүхий газарт олгосон хууль бус ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлуулахаар Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасны дагуу хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.

“Хил хязгааргүй хуульчид” ТББ-аас төсөл хэрэгжүүлж буй оюутнуудад 2 долоо хоног тутамд сургалт хийж, ТББ-ын идэвхтэн, захиргааны хэргийн шүүгч, ХЭҮК-ийн гишүүн зэрэг мэргэжилтнээр зөвлөгөө, мэдээлэл өгүүлэв. Мөн оюутнуудын хөндсөн нийтийн эрх ашгийн чухал асуудлуудыг олон нийтэд таниулах замаар асуудлыг ил гаргах, цаашлаад иргэдэд эрх зүйн мэдлэг болгох үүднээс 2023 оны 10 сарын 13-22-нд Монументаль арт

галлереид “Хязгааргүй” гэрэл зургийн үзэсгэлэн зохион байгууллаа.

Оюутны стратегийн өмгөөллийн 2023 оны хөтөлбөрийн үр дүнд эрх зүйн хөтөлбөрт интеграцчилж болох нийтийн эрх ашгийг шүүхээр нэхэмжлэн хамгаалах сургалтын хөтөлбөр, агуулга, гарын авлага бэлэн болов. Уг багц материалыг оюутны клиник сургалтын хөтөлбөрт нэвтрүүлэхээр “Хил хязгааргүй хуульчид” ТББ нь МУИС-ийн Хууль зүйн сургууль, Санхүү, эдийн засгийн их сургууль, Идэр их сургууль, Улаанбаатар их сургууль, Шихихутаг, Сити их сургуулийн Клиник сургалтын төвтэй хамтран ажиллаж байна.

Түүнчлэн, “Хил хязгааргүй хуульчид” ТББ нь “Залуу хуульчдын клуб” байгуулж, 28 хүртэлх насны залуу хуульчдад нийтийн эрх ашиг, нийтийн эрх ашгийг шүүхээр нэхэмжлэн хамгаалах, захиргааны эрх зүйн тодорхой асуудлуудаар мэдээлэл хүргэлээ. 2023 онд Залуу хуульчдын клубын гишүүд иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх цуврал подкаст, иргэдэд зориулсан иргэн, эрүү, захиргааны эрх зүйн тусламжийн гарын авлага боловсруулан хэвлэлд шилжүүлсэн амжилттайгаар энэ оныг үдлээ.



“Хязгааргүй” гэрэл зургийн үзэсгэлэн. 10 сарын 13. Монументаль арт галлереи

ТӨСВИЙН ХУВААРИЛАЛТАД ИРГЭДИЙН ШУУД ОРОЛЦОО

Иргэд амьдарч буй баг, хорооныхоо нутаг дэвсгэрт сайжруулах шаардлагатай асуудлыг дэвшүүлэн тавьж, тэндээс хамгийн олон санал авсан санаачилгыг Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-аас санхүүжүүлдэг хуулийн зохицуулалт 2013 оноос хэрэгжиж буй. ННФ нь “Тогтвортой хөгжлийн төлөөх сэтгүүлчид” ТББ-ын санаачилсан иргэдийг ОНХС-ийн шийдвэр гаргалт, санхүүжилт, хороонд хийх ажлын гүйцэтгэлд хяналт тавьж идэвхтэй ажиллахад уриалах, мэдээлэлээр хангахад чиглэсэн төслийг дэмжиж ажиллалаа. Уг төслийн хүрээнд ОНХС-ийн хуулийн дагуу шийдвэр гаргалт, хэрэгжилтийн зангилаа үеийг зурагласан цаглабар гаргаж, товлосон хугацааны дагуу хуулийн хэрэгжилтэд мониторинг хийж, үр дүнг иргэдэд тогтмол мэдээлж байв. Энэ туршлагадаа үндэслэн, ОНХС-ийн хуулийн дагуу мэдээлэл цаг бүртээ гарч буй эсэхэд хэрхэн мониторинг хийх аргачлалыг боловсруулж, нийтлэл, богино видео, цахим сургалтаар тайлбарлах, сонгогдсон 9 хорооны фейсбүүк хуудас болон нийгмийн сүлжээгээр бүх нийтэд сурталчлан таниулах үйл ажиллагаа хэрэгжүүлээ.

“Тогтвортой хөгжлийн төлөөх сэтгүүлчид” ТББ нь төслийн хүрээнд мэдээ мэдээлэл, нийтлэл, постер буюу зурагт мэдээ, видео сурвалжилга, ярилцлага зэрэг 130 орчим нэгж мэдээлэл бэлдэж, mpress.mn болон цахим сүлжээгээр түгээсэн нь 20,000 орчим хандалт авчээ. ОНХС-ийн асуудлаар ажиллах сонирхолтой сэтгүүлчдэд зориулж “Мэдээний өрөөнөөс” нэртэй влог бэлтгэн, фэйсбүүк болон твиттер дэх хуудсаар шууд дамжуулалтууд хийж, богино хэмжээний видео бичлэгүүд нийтэлж байсан нь 90 мянга гаруй хэрэглэгчид хүрсэн байна. Мөн 10 залуу сэтгүүлчийг ОНХС-ийн асуудлаар сургалтад хамруулжээ.

ОНХС-тай холбоотой мэдээллийг дүүрэг, хороод өгөхгүй байх явдал багагүй гарсан бөгөөд энэ нь төслийн үйл явцад хүндрэл учруулж байв. Ихэнх иргэн ОНХС-ийн талаар мэддэггүй, ОНХС-д санал өгч байсан иргэд хорооны хэмжээнд шийдэх шаардлагатай асуудлуудаар мэдээлэл ирдэггүй тул зөвхөн өөрийн мэддэг асуудлыг хөнддөг байна. Цаашилбал, хорооны иргэдээс ямар саналууд ирснийг хэрхэн эрэмбэлж дүүрэгт илгээсэн тухай, дүүргийн ИТХ нь ямар үндэслэлээр зарим төслийг дэмжиж, заримыг нь дэмжээгүй тухай, шийдвэр хэрхэн гардаг тухай мэдээлэлгүй тул итгэл үнэмшил муутай байна. Хорооны ажилтнууд иргэдийн оролцоо сул учраас гэрээр нь явж ОНХС-д саналаа өгөхийг уриалдаг ч тэд үүнд дуртай ханддаггүй гэж байхад иргэд өгсөн саналыг нь тусгадаггүй, хорооны ажилтнууд өөрсдөө бөглөж явуулдаг гэж боддог байна. ОНХС-ийн үйл явцад иргэд итгэл муутай байгаа нь мэдээлэл дутуу, шийдвэр гаргалт ил тод биш байгаатай холбоотой. Цаашилбал, шийдвэр гаргах үйл явцыг хуульд зааснаас өөрөөр хэрэгжүүлж буй зөрчил нэлээд илэрлээ. Жишээлбэл, ОНХС-ийн тухай хуульд заасан хугацааг баримталдаггүй, тухайлбал, иргэдээс санал авах, иргэдийн саналыг эрэмбэлэн дүүрэгт илгээх, дүүрэг болон нийслэлийн ИТХ-аар төслүүдийг хэлэлцэн батлах хугацааг дураар тогтоож, амаар мэдээлэн хэрэгжүүлэх практик хэвшсэн байна. Цаашилбал, ОНХС-аас санхүүжих төсөл нь орон нутгийн Засаг даргын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд нийцсэн байх тухай заасан журам гарсан нь иргэдийн саналаар төсвийн хуваарилалт хийх ОНХС-ийн үндсэн зориулалтыг зөрчсөн, хуулиас давсан журам болжээ. Эдгээр асуудлыг олон нийтэд нийгмийн сүлжээгээр мэдээлэхийн зэрэгцээ нийслэлийн ЗДТГ-т мэдээлж, нөлөөллийн ажил эхлүүлсэн боловч нийслэлийн Засаг даргын баг солигдсоноор тодорхой ахиц гараагүй байна.

АРДЧИЛЛЫН, СОНГОГЧИЙН ЧУХАЛ УР ЧАДВАР БОЛОХ МЭДЭЭЛЛИЙН БОЛОВСРОЛ

Худал, ташаа мэдээлэл нь олон нийтийг хагаралдуулах арга хэрэгсэл болж, ардчилсан тогтолцоонд итгэх итгэлийг унагаж, улмаар иргэний оролцоог бууруулснаар [Sanchez G., Meddlema, K., 2022, *Misinformation eroding the public's confidence in democracy* нийтлэл. <https://www.brookings.edu/articles/misinformation-is-eroding-the-publics-confidence-in-democracy/>] зарим иргэн худал, ташаа мэдээлэлд автан радикал, хүчирхийлэлтэй арга замыг сонгох, зарим нь улс төрийн амьдралд огт оролцохгүй байх сонголт хийхэд хүрдэг байна [Эх сурвалж: А. Маати нар, 2023, *Information, doubt, and democracy: how digitization spurs democratic decay* өгүүлэл, *International Studies Review*, Volume 25, Issue 2, June 2023 <https://www.tandfonline.com/doi/epdf/10.1080/13510347.2023.2234831?needAccess=true>]. Худал, ташаа мэдээлэлтэй тэмцэх гол арга хэрэгсэл бол төрийн ил тод байдал, иргэний оролцоо, чөлөөт хэвлэл мэдээлэл, мөн хувь хүмүүст худал, ташаа мэдээлэлд автахгүй байх мэдээллийн боловсрол олгох явдал болохыг олон улсын байгууллагууд зөвлөдөг [Жишээлбэл, OECD, 2023, *Building Trust and Reinforcing Democracy: Preparing the Ground for Government Action*, <https://www.oecd-ilibrary.org/sites/1f76484d-en/index.html?itemId=/content/component/1f76484d-en#section-d1e243>].

ННФ нь 2023 онд олон нийтийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр “Сэтгүүл зүйн хөгжил, инновацын ҮҮР төв” (ҮҮР төв), “Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв” ТББ-уудтай хамтран ажиллалаа.

ҮҮР төв нь олон нийтэд цахим сүлжээгээр хүлээн авч байгаа мэдээллийн үнэн зөвийг нягтлах арга, аргачлалыг хүргэх олон нийтийн боловсролын төсөл хэрэгжүүлээ. Тус төв нь фэйсбүүк хэрэглэгчдэд хандан, нийгмийн сүлжээнд хүлээж авсан мэдээллийг бусадтай хуваалцахаас өмнө эх сурвалж, гарчиг, агуулгыг нягтлах, хуурамч мэдээллийг таних

аргыг тайлбарласан зурган болон дүрстэй цуврал бүтээлүүд бэлтгэн нийтэд хүргэв. Мэдээллийн боловсролыг олон нийтэд хүргэх зорилгоор “Нягталъя” өдөрлөгийг 06 дугаар сарын 24-ний өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулж, 200 орчим хүн хамрагдаа. Өдөрлөгөөр хэвлэмэл материал тараах, амаар мэдээлэл тайлбарлахын зэрэгцээ асуулт, хариулт, дадлага ажил, тоглоом зэргээр дамжуулан хүлээн авсан мэдээлэл нягтлах хэрэгцээг ойлгуулж, мэдээллийн эх сурвалжийг нягтлах аргуудыг заасан юм.



“Нягталъя” өдөрлөг. 6 дугаар сарын 24. Үндэсний цэцэрлэгт хүрээлэн

Төслийн хүрээнд бэлдсэн материалаа ашиглан ҮҮР төв нь мэдээллийг нягтлах сургалтын хөтөлбөр бэлдэж, сонирхсон иргэд, ТББ-ын идэвхтнүүдэд цахим болон танхимын сургалтаар хүргэж байна.

“Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв” (www.factcheck.mn) ТББ нь мэдээллийг нягтлах арга зүйд түшиглэсэн сонгогчийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлд ННФ-тай хамтран ажиллалаа. Уг хөтөлбөрт Улаанбаатар хот болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч, редакторууд оролцсон юм. Тэд уг хөтөлбөрийн хүрээнд баримт нягтлан

шалгах арга зүйд түшиглэсэн сэтгүүл зүйн бүтээл гаргах бие даасан төслүүд хэрэгжүүлээ.

2023 оны 4 дүгээр сард зарласан уг тэтгэлэгт хөтөлбөрт Улаанбаатараас 20, орон нутгаас 20 сэтгүүлч шалгарсан бөгөөд төрд хяналт тавих болон эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үүрэг, сонгууль, сонгогчийн боловсрол, баримт нягтлах, нийтлэл бичих үр чадвар зэрэг сэдвээр цуврал сургалтад хамрагдав. Улмаар хөтөлбөрийн оролцогчид менторын дэмжлэгтэйгээр бие даасан болон хамтарсан төсөл боловсруулж, эрэн сурвалжлах болон баримт нягтлах арга зүйд түшиглэсэн нийт 23 бүтээл гаргаж, олны хүртээл болголоо.

ОРОЛЦОГЧДЫН ЗАРИМ БҮТЭЭЛ

№	Овог, нэр	Бүтээлийн нэр	Бүтээлийн холбоос
1	Б.Должинжав	Бизнесээ өргөжүүлэх гэж төр рүү зүтгэдэг гишүүдийг дахин сонгохоо больё	https://ivoice.mn/?p=71776&fbclid=IwAR3pvBosvgwXEj7bb077uFo2WlhydXWHotgCU-lmTleCkZ9vuUKRxpPWDvww
3	С.Юмсүрэн	Өндөр өсгийтийн хүч	http://unenmedee.mn/1tr?fbclid=IwAR1aWg1Hj3lys_v1yKIQF3bdoKWcp8_7F_EmDNNGW3c7poxnLwByBTLIFyl

№	Овог, нэр	Бүтээлийн нэр	Бүтээлийн холбоос
3	Д.Уржинбадам	Иргэдийн татвараас санхүүжсэн намууд зарцуулалтаа тайлагнахгүй байна	https://news.zindaa.mn/4n5k?fbclid=IwAR141z8D-if1UGUN00gBqfBeT3F3MULVEi9lrk4Z8hA4eSpgRy6oyQYI2HM
4	Г.Одгарав	Инфографик: Төрөөс зээл авсан гэгдэх түшээд хэр баян бэ?	https://graph.mn/news/316
5	А.Марал	Намуудын санхүүжилтийг мэдье	https://unread.today/c/explained-political-party-funding
6	Г.Тэгшсүрэн	"Бэлгийг нь авчихсан юм чинь" буюу биднийг ядуу байдалд дасгах тэдний технологи	https://gogo.mn/r/g7w6e?fbclid=IwAR2nyL2V-n-97P28IGvJJoTW7u967MVWK2ygmS48hvp900iFmsGWz7mHBU
7	Э.Намуун	FactCheck: Монголын парламентын хүйсийн төлөөлөлд "шодоргос" хэрэгтэй байна	https://ub.life/p/31964?fbclid=IwAR1CTaU2o3ggf39K60IYF0T_YhQjdFOPeii5D5I22LPu5ni3wnFtQt65zx8
8	Б.Баярцэцэг	Иргэний үнэмлэхийн хаяг дээрээсээ сонгуульд саналаа өгөх ёстой	https://www.facebook.com/watch/?v=832309541170399&extid=CL-UNK-UNK-UNK-AN_GK0T-GK1C&mibextid=T3FBdp&ref=sharing
9	Г.Батжаргал	Factcheck: Анх удаа УИХ-ын гишүүн болсон 32 хүний орлого ИНГЭЖ ӨӨРЧЛӨГДЖЭЭ	https://itoim.mn/a/2023/06/29/article/btl?fbclid=IwAR02jffK5yk2J__AKzoDeTpNpgg9LNgBnfYcxlZd1HAe9bF850RrpxLYyqk
10	А.Нямаа	УИХ-ын гишүүд үндэслэлтэй хөрөнгөжиж байна уу?	https://peak.mn/news/uikh-iin-gishuud-undesleltei-khurungujj-baina-uu?preview=true&fbclid=IwAR3WS9KDTuW4eKGeCBvQVAZvx9FDYEzRatyDIN8RP3m0bZlguVgylHpoVy8
11	Б.Дуламсүрэн	ДАТА ИНФО: УИХ-ын гишүүн болбол хөрөнгөө хэрхэн өсгөж болдог вэ?	https://tand.mn/5017?fbclid=IwAR0tVGjkARU96dzKigi_hmDCF1btKXd2WB31kdmldb4vWuJ5MgRCraterLU
12	Б.Мөнх-Эрдэнэ, Завхан аймаг	Амлалт нисэн одож, цаас үлддэг	https://peak.mn/news/amlalt-nisen-odoj-tsaas-ulddeg?preview=true&fbclid=IwAR2GZOV_VH3j08Cxd6Pin0-Xw6YDxfFMM3FIB03NoHpER1EOpPwmJmtlsh4
13	А.Саранчимэг, Орхон аймаг	Төрийн өндөр сэнтийгээс сонгогчийн саналд нөлөөлөх технологи буюу эрдэнэт элэгтэй нутгийн сайд	https://etimes.mn/news/79384?fbclid=IwAR1TyA7kAR4KNGvMXdcCl4jmXShY7tiie5kBKqDzBapHd7h_NBOzGsf73U
14	Ж.Саруул, Орхон аймаг	Өнөөдөртөө санал өгдөггүй ч тэдний асуудал өнө хойчдоо хамгийн хор уршигтайгаар ирэх юм биш биз	https://peak.mn/news/utshot?fbclid=IwAR0PI2j-_TwKhCbflUVgPVYXxbMrnybsbYukPr5mSwi85IGITt4IURHnE

Сонгогчдын ирц 1992-2021 онд тогтмол буурчээ

“Сонгогч иргэний үнэмлэх дээрх хаягаасаа сонгуулиа өгөх ёстой. Гэвч 18-34 насныхан харьяаллын газраасаа өөр газар ажиллаж, суралцах нь элбэг. Байгаа газраасаа санал өгөх боломжтой гэж судлаачид хэлдэг ч манай улс сонгуулийн санал өгөх ганцхан хувилбартай. Энэ нь жилээс жилд сонгогчдын ирц буурах шалтгаан байхыг үгүйсгэхгүй”

NTV телевизийн Сэтгүүлч Б.Баярцагц

Монголын парламентын хүйсийн төлөөлд “шодоргос” хэрэгтэй байна

“Манай улсын хүн амын тал хувийг бүрдүүлдэг нь эмэгтэйчүүд атлаа шийдвэр гаргах түвшинд 30 хувийг ч бүрдүүлж чадахгүй байгаагийн учир юунд байна вэ? Олон шалтгаан байж болох ч энэ удаагийн нийтлэлдээ улс төрч эмэгтэйчүүдийг цахим орчинд “ялдааг”, урам зоригийг нь мохоодог байдал нийгэмд түгээмэл байгааг баримтаар нотолж харуулахыг зорилго. Эмэгтэйчүүдийн дуу хоолой нийгэмд хангалттай хүрэхэд хэвлэл мэдээллийнхэн онцгой үүрэгтэй байгааг нийтлэлдээ хөндхийг хичээсэн юм”

www.ub.life
Вэбсайтын редактор Э.Намуун

“Бэлгийг нь авчихсан юм чинь” буюу биднийг ядуу байлгах технологи

“Саяхнаас кока кола ундааны бөглөө нь улаан байснаа шар болчихсон доо. Түүнээс хойш савлагаа нь нэг тийм эв хавгүй харагдаад байх болсон. Энэ мэтчилэн бид аливаад амархан дасчихдаг. Улстөрчид тойргийн иргэддээ гарын бэлэг гардуулж, тэр үйлдлээ давтаж байгаа нь сонгогчдынхоо нүдэнд дасам, сэтгэлд хоногших гэсэн л тактик шүү дээ. Ийм башир аргаар сонгогчдын саналыг авч буй нь өнөөдрийн сул дорой нийгмийг бүтээхэд нөлөөлж байна гэдгийг энэхүү нийтлэлээр дамжуулан хэлэхийг зорьсон.”

www.gogo.mn
Мэдээллийн сайтын сэтгүүлч Г.Тэгшсүрэн

Намуудын санхүүжилтийг мэдье

“Одоо цагт ажил хийвэл биш нам дагавал ам тосдох болжээ. Нам бол засгийн эрхэнд гарах туйлын зорилготой бүлэг хүмүүс. Тэрхүү ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхийн тулд хаанаас, хэнээс санхүүжиж, сонгуульд хэрхэн оролцдог тухай өөрийн бүтээлээрээ мэдүүлэхийг зорьлоо.”

www.unread.today
Вэбсайтын сэтгүүлч А.Марал

№	Овог, нэр	Бүтээлийн нэр	Бүтээлийн холбоос
15	Э.Бодьгэрэл, Дархан-Уул аймаг	Орь залуу насныхны Орхигдол буюу нягтлах сэдлийг нь тэдэнд олго	https://ubn.mn/p/53358?fbclid=IwAR1WAM5HnGiBHewnp4hHux5jDCiJP_3ByEOx5Xt2gkNbKrCz1JUNFtSqoM
16	Б.Ганчимэг, Орхон аймаг	Тэгш эрхтэй ч тэгш боломжгүй боловсролын тогтолцоо эцэг, эхчүүдийг цөхрөөж байна	https://ikon.mn/n/30m9?fbclid=IwAR23oz5vN3SxFNSMSf2bmATBmsmSQWUjJhifuNNRVukfj1vfcaFOLRTEM
17	Т.Одончимэг, Сүхбаатар аймаг	Худал мэдээллээр иргэдийн тархийг угаагч тролл компани орон нутагт ч байна	https://sbinfo.mn/?p=33303&fbclid=IwAR0idYAGEJDGbkK4zZDQu804Vff7Avpni0831t0mPOCP-U34EOVMxDt36U
18	Э.Одсүрэн, Орхон аймаг	Бэлэн амлалт, мянган хүлээлт	https://ikon.mn/n/30l8?fbclid=IwAR0bTgcdz4ERbjqUaGE_h8Ewnp5FQy4ynpuWTeVaSAihT4I_8rEHaA_VyI8
19	Н.Отгонжаргал, Хөвсгөл аймаг	Төрийн албан тушаалтан үү? Томилсон намын гишүүн үү?	https://gerel.org/?fbclid=IwAR0oNEFE0cNNCXczlZKMntGPPriO3gNujHxQJWbLUdn_-1jju3Vupl0VaRY
20	Б.Мягмарсүрэн, Завхан аймаг	Манайх л битгий ялагдаасай, боломжоо алдах вий гэсэн айдастай сонгогчдыг мэдээлэлтэй болгоё	https://peak.mn/news/songuuliin-ur-dungees-zarim-songogch-aij-baina?fbclid=IwAR1-0wkQha8BKX11V073d9m-HIb-itRFW4ycjXal-nUhnPeVINNAqcyhHZA
21	Ч.Отгонцэцэг, Сэлэнгэ аймаг	Сонго ба үйл	https://peak.mn/news/songogchdiin-bolowsrol?preview=true

Хөтөлбөрийн хоёр онцлогийг дурдах хэрэгтэй. Нэгд, оролцогчдын идэвхийг дэмжих, мөн гаргасан хүчин чармайлтыг үнэлэх зорилгоор гурван бүтээлийг тодорхой шалгуурын дагуу шалгаруулан, шагнахаар зарласан ч хүчтэй өрсөлдөөний үр дүнд дээрх дөрвөн бүтээл шалгарсан юм. Хоёрт, хөтөлбөрийн бүхий л үйл ажиллагааг “Долоо нягталж, нэг сонго” уриан дор зангидан хэрэгжүүлээ.



Улмаар уг уриа нь цаашид “Эрэн сурвалжлах сэтгүүлчдийн төлөө төв” ТББ-ын сонгогчийн боловсрол, олон нийтийн боловсролын үйл ажиллагааны уриа, өнгө төрх болж үргэлжлэн ашиглагдахаар болов. Уг ТББ нь тэтгэлэгт хөтөлбөрийнхөө хүрээнд эхлүүлсэн иргэний боловсролын “7 минут, 7 хариулт” подкастыг цааш тогтвортой үргэлжлүүлэхээр төлөвлөж байна.



ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГО

ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР




ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ИНДЕКС

2008 оноос эхлэн шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх зорилгоор судалгаа шинжилгээ, олон талын оролцоо бүхий бодлогын хэлэлцүүлэг зохион байгуулж иржээ. Өнгөрсөн хугацаанд хуримтлуулсан шүүхийн салбарын судалгаа шинжилгээний түршлага, олон улсад туршигдсан эрх зүйн салбарын үнэлгээний арга зүй, дотоодын шинжээчдийн үнэтэй зөвлөгөөний дагуу үндэсний индексийн арга зүйг тодорхойлон Монгол Улсын шүүхийн нөхцөл байдлыг 2021 оны байдлаар үнэлж, индекс буюу тоогоор илэрхийлэх судалгааг 2022 онд олон нийтэд танилцуулсан билээ. Шүүхийг олон нийтийн болон салбарын мэргэжилтнүүдийн санал, захиргааны өгөгдөл, мэдээлэл гэсэн гурван эх

сурвалжид суурилсан 6 үндсэн хэмжигдэхүүнээр үнэлдэг энэхүү үнэлгээг цаашид хоёр жил тутамд танилцуулах бөгөөд 2023 оны мэдээлэлд үндэслэн хоёр дахь тайланг 2024 онд танилцуулах юм. 2023 оны эцэст төсөөллийн судалгааг “ММСГ” судалгааны компани гүйцэтгэж буй бол мэргэжилтнүүдийн санаа бодлын судалгаа болон захиргааны тоон мэдээлэлд хийх дүн шинжилгээг “Оюуны-Инноваци” ТББ хийж байна.

Түүнчлэн Шүүхийн индексийн эхний тайланг англи хэл дээр орчуулж, нийтэлсэн бөгөөд Монгол Улсын шүүхийн шинэтгэл, сорилт, бэрхшээлийн талаар таньж мэдэх англи хэл дээрх чухал эх сурвалж болсон гэдэгт итгэлтэй байна.



<https://forum.mn/product/325780>

Энэхүү индексийн судалгааны үр дүнг танилцуулах үүлзалт, хэлэлцүүлгийг Улсын дээд шүүх, Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн Ерөнхий зөвлөл зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.

Түүнчлэн 3 дугаар сарын 22-ны өдөр болсон “Хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх ба шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх нь” сэдэвт Олон Улсын бага

хуралд ННФ-ын Эрх зүйн хөтөлбөрийн менежер П.Бадамрагчаа нь Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, ШСХ-ны гишүүн Д.Давхарбаяр нарын хамт “Шүүгчийн ёс зүй ба сахилга, олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх нь” сэдвийн хүрээнд хэлэлцүүлгийг удирдаж, хуралд оролцогчдод байр сууриа илэрхийлсэн юм.



https://www.facebook.com/watch/live/?ref=watch_permalink&v=718230786754945

ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ҮЗҮҮЛСЭН ДЭМЖЛЭГ

ШЕЗ-ийн хүсэлтээр шүүхийн байрны стандарт боловсруулах суурь судалгааг ННФ-ын дэмжлэгээр Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэн хийж гүйцэтгэн ШЕЗ-д танилцуулав. Уг судалгааны хүрээнд шинээр байгуулагдан ажиллаж буй Шүүхийн сахилгын хорооны үйл ажиллагааны хараат бус байдлын баталгааг хангахад чухал ач холбогдол бүхий шүүгчийн сахилгын хэргийн бүртгэл, мэдээллийн системийг боловсруулан

үйл ажиллагаанд нь бүрэн нэвтрүүлээ. Мөн сахилгын хэрэг хянан шийдвэрлэсэн өнгөрсөн 2 жилийн туршлагад үндэслэн сахилгын маргаан шийдвэрлэх нарийвчилсан процессын журам болон бусад холбогдох журмын төсөл боловсруулах чиглэлээр судлаач, хуульч Л.Галбаатартай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан хамтран ажиллаж, холбогдох хуулийн төслүүдийг боловсруулан зохих ёсны байгууллагуудад хүлээлгэж өгөөд байна.

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2023 онд шүүхийн шийдвэрийн судалгааг ахисан шатанд гаргаж, хэрэгцээ шаардлагатай сэдвээр хийх бодлогын хүрээнд нийт 37 байгууллага, албан тушаалтанд судалгааны сэдэв ирүүлэх хүсэлт илгээн давхардсан тоогоор 102 сэдэв хүлээн авсан юм. Шүүхийн шийдвэрийн судалгааны хүрээнд байгуулагдсан Редакцын зөвлөлийн хурлаар сэдэв тус бүрийн ач холбогдлыг үнэлэн шигшиж, нийт 17 сэдэв сонгон шалгаруулан, зарласнаар нийт 20 төсөл хүлээн авсан юм. Үүнд ННФ-ын Удирдах зөвлөлийн гишүүд үнэлгээ хийж 8 төсөл сонгон шалгаруулж судалгааны гэрээ байгуулан хамтран ажилласан нь доорх цувралууд болно.

“Оюуны-Инноваци” ТББ-тай хамтран хамтран LegalTalks подкастын “Шүүхийн шийдвэр судалгаа” тусгай цувралыг 2022 оны эцсээс эхлэн, энэ онд бэлтгэн олон нийтэд хүргэлээ. Тус ТББ нь хуульч, эрх зүйч, судлаач нарт зориулан эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, сэдвийн талаар дэлгэрүүлэн хэлэлцэх, түгээх, салбарын шинэ соргог болон тулгамдсан асуудал, мэдээ мэдээллийн талаар мэргэжлийн, сонирхолтой яриа өрнүүлэх зорилго бүхий LegalTalks подкастыг эрхлэн бэлтгэдэг бөгөөд хамтарсан гэрээний хүрээнд 18 дугаар бэлтгэн (https://forum.mn/irgenii-bolovsrold?category_id=16212) нийтийн хүртээл болгоод байна.



<https://forum.mn/product/282858>



<https://forum.mn/product/329712>



<https://forum.mn/product/332979>

МОНГОЛ УЛСАД СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛЖ БҮЙ ШҮҮХИЙН ПРАКТИК

1. Танилцуулга 00:00-06:15
 2. Сэтгэл санааны хохирлыг нэхэмжлэх шаардлага, үндэслэл болон сэтгэл санаанд учирсан хохирлын ойлголтын тухай 06:15-15:05
 3. Сэтгэл санааны хохирлыг гаргуулахад тулгамдаж буй асуудал, хууль эрх зүйн орчин, шүүхийн практик 15:05-21:07
 4. Сэтгэл санааны хохирлыг гаргуулахтай холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чиглэсэн судалгааны санал, зөвлөмж, сорилт, үр дүн 21:07-30:25
 5. Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгаар орсон хохирлыг тогтоох зохицуулалт, үр дүн, шинэчлэлийн тухай 30:25-

ХӨТӨЛӨГЧ:
П.Бадрамрагчаа: Нээлттэй Нийгэм Форумын Эрх зүйн хөтөлбөрийн менежер

ЗОЧИН:
А.Түвшинтөгс: Өмгөөллийн Номун түншлэл компанийн өмгөөлөгч

"Шүүхийн шийдвэрийн судалгаа" цуврал подкаст

S2 EP1

<https://forum.mn/product/332468>

<https://forum.mn/product/356731>

Иргэдийн шударгаар шүүлгэх эрхийн тулгамдсан асуудлын нэг болох өмгөөлөгчийн эрх үүргийн талаарх энэхүү судалгааны ажлуудыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж буй бодлого боловсруулах, шийдвэр гаргах албан тушаалтнууд анхааралдаа авч, цаашдын үйл ажиллагаандаа тусгана гэдэгт найдаж байна.

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН МОНИТОРИНГ

2021 онд хэрэгжүүлсэн шүүхийн шийдвэрийн нээлттэй өгөгдлийн сангийн мониторингийн үр дүнд шинээр томилогдсон ШЕЗ шүүхийн шийдвэрийн цахим сангийн холбогдох журмыг шинэчлэн баталж хэрэгжүүлж эхлээд байна. 2023 оны 3 сараас нээлттэй зарын дагуу эрүү, иргэн, захиргааны шүүхийн шийдвэр цахим санд байршиж эхэлсэн бөгөөд үүнд мониторинг хийх төслийн үрэлдээн зарлаж нийт 10 төсөл хүлээж авснаас эрүү, иргэний шүүхийн шийдвэрийн санд орон нутгийн судлаач, иргэний нийгмийн баг шалгарсан бол нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг нийтэлж буй байдалд МУИС-ийн ХЗС-ийн практик сургалтын төвийн баг шалгарсан юм. Багууд мониторингийн төслийг амжилттай хэрэгжүүлж, нэгдсэн тайлангаа боловсруулан хэвлэж, уншигчдын хүртээл болгоод буй.


Шүүхийн шийдвэрийн цахим сангийн эхлэл тавигдаж, нийтэд мэдээлэл түгээдэг болоод 10 жилийн нүүр үзсэн хэдий ч шүүхийн шийдвэрүүд цаг хугацаандаа нийтийн хүртээл болж тэр бүр чадахгүй байна. Монгол Улсын нийт шүүхийн хэмжээнд хэрэг хянан шийдвэрлэсэн шийдвэрийн тал нь тухайн жилдээ багтаж мэдээллийн санд орохгүй байгаа нь мэдээллийн ил тод байдал бүрэн хангагдаагүйг илтгэнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг үнэлэх чиглэлээр захиргааны шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийн нөхцөл байдалд мониторинг хийж, сэдэвчилсэн тайланг нийтэллээ.

<https://forum.mn/product/367340>

Үүний зэрэгцээ “Оюуны-Инноваци” ТББ “Өмгөөлөгчийн эрхийг баталгаажуулах, үйл ажиллагааны баталгааг хангах” асуудлаар нийтийн эрх ашгийн өмгөөллийн төсөл хэрэгжүүлсэн нь өмгөөллийн үйл ажиллагааны баталгааг хангах нөлөөллийн ажилд чухал ач холбогдол болсон юм.

Түүнчлэн хөтөлбөрийн үйл ажиллагааны хүрээнд АТГ-ын даргын тушаалаар байгуулагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг, дэд ажлын хэсэг, УИХ-д хөтөлбөрийн төсөл өргөн барьж батлуулах ажлын хэсэгт мөн ажиллаж, 2023 оны 6 сарын 30-ны өдөр УИХ-ын чуулганаар “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” тогтоолын төслийг батлуулаад байна.



НИЙТИЙН БАЯЛГИЙН УДИРДЛАГА, ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ

ТӨСВИЙН ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР



“Төсвийн хариуцлагыг дээшлүүлэх” хөтөлбөрийн хүрээнд улсын төсөв, санхүүгийн удирдлага, цаг үеийн асуудлуудаар тогтмол судалгаа, шинжилгээ хийж, үр дүнг нийтэд хүргэх, төсвийн зарцуулалтад хяналт

тавин ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр хамтран ажиллаж ирлээ.

ТӨСӨВ, САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫГ ХӨГЖЛИЙН БОДЛОГОД ЧИГЛҮҮЛЭХ НЬ

Нээлттэй Нийгэм Форум (ННФ)-ын дэргэд 2021 онд байгуулагдсан “Төсвийн зөвлөл” нь нийтийн сан хөмрөгийн оновчтой зарцуулалтыг дэмжих үүднээс улсын төсөв, санхүүгийн чухал асуудлуудаар тогтмол хэлэлцэж ирсэн бөгөөд энэ онд төсөв, санхүүгийн удирдлагын эрхзүйн орчныг боловсронгуй болгоход багагүй хувь нэмэр орууллаа. Тодруулбал, төсвийн шинэчлэлтэй холбоотой хуулиудын төслийг хэлэлцэн, саналаа 2022 онд УИХ-ын Төсвийн байнгын хороонд хүргүүлэв. Түүнчлэн УИХ-ын Төсвийн байнгын хорооноос 2023 оны 4 дүгээр сард зохион байгуулсан “Төсвийн шинэчлэл” хэлэлцүүлэгт оролцон байр сууриа илэрхийлсэн юм.

Зөвлөлийн энэхүү үйл ажиллагаа нь 2023 оны 7 дугаар сард Төсвийн тухай хуульд орсон өөрчлөлтөд төсвийн удирдлагыг боловсронгуй болгох чиглэлээр нааштай заалтууд тусахад чухал нөлөө үзүүллээ. Онцолбол, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх, хянах, тайлагнах, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэхдээ кодчилох заалтыг хуулийн төсөлд оруулсан юм. Ийнхүү цаашид төслийн кодыг үндэслэхээр болсон нь төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн бүртгэл, мэдээллийн иж бүрэн байдлыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.




Төсвийн зөвлөлөөс эрхлэн гаргасан төсвийн шинжилгээ <https://forum.mn/post/131278>



Монгол Улсын 2024 оны төсвийн төсөвлөлт <https://forum.mn/product/327266>

Түүнчлэн төсвийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах хүрээнд Засгийн газар олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, байнгын ажиллагаатай санал авах цахим хуудас, шуурхай утас ажиллуулах, хэлэлцүүлгийг салбар бүрээр явуулах, гарсан саналыг тухайн жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөлд хэрхэн тусгасан талаарх мэдээллийг нийтлэх зэрэг шаардлагууд Төсвийн тухай хуульд шинээр тусгалаа олов. Цаашилбал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад ашиглах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалын тооцоог хийж, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэхээр хуульд тусгаад байна.

Цаашилбал “Төсвийн зөвлөл” нь хараат бус судлаачдын зүгээс гүйцэтгэсэн “Шилэн дансны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд өгөх санал, шүүмж”, “Монгол Улсын төрийн гадаад өрийн төлөв байдал” тайлангуудыг хэлэлцэн санал, шүүмж өгөхөөс гадна доорх төсвийн шинжилгээг эрхлэн, олон нийтэд хүргэв. Мөн улсын төсвийн цаг үеийн асуудлаар тогтмол хэлэлцүүлэг, уулзалтууд зохион байгуулж ирлээ.



Төсвийн зөвлөлийн гишүүд 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэв. <https://forum.mn/post/130085>

Төсвийн хөтөлбөрийн хүрээнд улсын төсөв, санхүүгийн удирдлагыг өнөөгийн түвшнээс дээшлүүлэхийн тулд хараат бус судлаачидтай хамтран судалгаа, шинжилгээ тогтмол хийж, дүгнэлт, зөвлөмж гарган ажиллаж байна. Үүнээс өнгөрсөн онд хийгдсэн судалгаануудаас онцолбол:



Засгийн газрын гадаад зээлийн мэдээлэл, төслүүдийн санхүүгийн ил тод байдал <https://forum.mn/product/271595>



Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө ба төсвийн уялдаа <https://forum.mn/product/272728>



"Монгол Улсын төрийн гадаад өрийн төлөв байдал" <https://forum.mn/product/326940>

Цаашилбал, "Эрдэнэс Тавантолгой ХК-ийн гэрээнүүдийн санхүүгийн шинжилгээ"-г хийж, судалгааны дүнг холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлээд байна.



"Монгол Улсын Засгийн газрын гадаад зээлийн мэдээлэл, төслүүдийн санхүүгийн ил тод байдал" судалгааны дүнг судлаач С.Баттулга танилцуулж буй нь, 2023 оны 3-р сар

ННФ-ын захиалгаар "Сэргэлт Консалтинг Групп" ХХК-ийн судалгааны баг Монгол Улсын төрийн гадаад өрийн хэмжээ, түүний цаашдын төлөв байдлыг тооцоолж, өрийн тогтвортой байдалд дүгнэлт өгсөн юм. "Засгийн газрын өрийн удирдлагын өнөөгийн тогтолцоонд Монгол Улсын төрийн өрийг бүрэн хэмжээнд авч үзэхгүй байна" <https://forum.mn/product/326940> хэмээх дүгнэлтийг судалгааны баг хийсэн ба төрийн өрийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн санал, зөвлөмж боловсруулж, нийтэд хүргэлээ.

Монгол Улсын 2024 оны төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгоход хувь нэмэр оруулах үүднээс мөн хараат бус судлаачид дүн шинжилгээ хийж, 2023 оны 10 дугаар сард зохион байгуулсан "Монгол Улсын 2024 оны төсвийн төлөвлөлт" сэдэвт хэлэлцүүлэгт танилцууллаа. Тухайлбал, Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024




"Монгол Улсын төрийн гадаад өр" сэдэвт хэлэлцүүлэг, 2023 оны 11 дүгээр сар

онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжууд нь 2023 оны 5 дугаар сард УИХ-аар батлагдсан "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-нд туссан төсөл, арга хэмжээтэй хэрхэн уялдаж буйд судлаач С.Баттулга дүн шинжилгээ хийсэн бөгөөд үр дүнгээ уг хэлэлцүүлгийн үеэр танилцуулсан юм.

Энэхүү дүн шинжилгээ нь цаашид хөгжлийн төлөвлөгөө ба төсвийн төлөвлөлтийн уялдааг сайжруулахад ач холбогдолтой хэмээн үзэж, "Чухал сэдэв" цувралдаа нийтэлсэн юм (<https://forum.mn/product/338482>). Түүнчлэн, судлаачдын зүгээс улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын шинэ болон шилжих

төслүүдийн төлөвлөлтийг шинжилж, хэлэлцүүлгийн үеэр танилцууллаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 21 хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах, өргөн барих зохицуулалтад өмгөөллийн "Фиделитас партнерс" ХХН-ийн Гүйцэтгэх захирал Б.Наранцэцэг дүн шинжилгээ хийж, мөн хэлэлцүүлгийн үеэр үр дүнг танилцуулсан юм. Энэхүү шинжилгээ нь цаашид тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэх хуулиудын зохицуулалтыг сайжруулахад ач холбогдолтой хэмээн үзэж, бид "Бодлогын асуудал" цувралынхаа 38 дахь дугаарт нийтлэв (<https://forum.mn/product/333892>).



“Санхүүгийн Хүртээмж Хөгжил Санаачилга” ТББ-ын судалгааны баг “Цалин болон халамжийн бодлого иргэдийн ажил эрхлэлтэд үзүүлж буй нөлөөллийн судалгаа” судалгаа <https://forum.mn/product/354752>



Фиделитас партнэрс ХХН-ийн судалгааны баг “Шилэн дансны тухай хуулийн төсөлд өгч буй санал, шүүмж” <https://forum.mn/product/274577>



Судлаач С.Баттулга “Монгол Улсын 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих төслүүдийн төлөвлөлт ба Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний үндэсэнд хийсэн дүн шинжилгээ” <https://forum.mn/product/338482>



Төсвийн гүйцэтгэл ба тогтвортой хөгжлийн зорилтуудын судалгаагаар тогтвортой хөгжлийн 17 зорилтоос 10 зорилтод нь хамааралтай 7 салбарын хувьд Монгол Улсын Засгийн газрын төсвийн зарлагын төлөвлөлт, гүйцэтгэлийн чиг хандлага болон тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийн байдлыг хамаатуулан судаллаа. Монгол Улс хөдөө аж ахуй, хүнс, байгаль орчин, хүйсийн тэгш байдал, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, ундны ус, ариун цэврийн байгууламжийн хангамж зэрэг 6 салбарын хувьд тогтвортой хөгжлийн зорилтдоо хүрэхэд ихээхэн сорилттой тулгарч байна. Тогтвортой хөгжлийн зорилтдоо хүрэхгүй байх эрсдэл бүхий эдгээр 6 салбарын хувьд төсвийн гүйцэтгэлийг сайжруулах хэрэгтэй байна. <https://forum.mn/product/306270>

“Монгол Улсын эрүүл мэндийн салбарын төсвийн гүйцэтгэлийн дүн шинжилгээ”-ний хүрээнд эрүүл мэндийн салбарын төсвийн зарлагын гүйцэтгэл болон түс салбарын хувьд дэвшүүлсэн Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн байдлыг авч үзлээ. Судалгаагаар эрүүл мэндийн салбарын төсвийн зарцуулалт төлөвлөсөн хэмжээндээ хүрэхгүй байгаа дүн гарчээ. Манай улсын хувьд Тогтвортой хөгжлийн 3 дахь зорилго буюу “Эрүүл мэндийг дэмжих” зорилгын хэрэгжилтийг хангахад ихээхэн сорилт тулгарч буй. Иймд эрүүл мэндийн салбарын төсвийн зарлагын гүйцэтгэл, удирдлагыг сайжруулах чиглэлээрх санал, зөвлөмжийг судлаачийн зүгээс гаргасан юм. <https://forum.mn/product/330744>



Цаашилбал хөтөлбөрийн хүрээнд дараах судалгаануудыг хийлээ. Үүнд:

- Төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн судалгаа;
- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдаг өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа;
- Хувь хүний орлогын албан татварт хамрагдаж буй орлогын эх үүсвэрүүд;
- “Цалин болон халамжийн бодлого иргэдийн ажил эрхлэлтэд үзүүлж буй нөлөөллийн судалгаа;
- Жижиг, дунд үйлдвэрлэлийн салбар дахь гарааны бизнест импортын нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулалтыг боловсронгуй болгох боломж зэрэг болно.

Олон улсын төсвийн түншлэл (ОУТТ) байгууллагатай өрнүүлж буй хамтын ажиллагааны хүрээнд ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам “Төсвийн нээлттэй байдал 2023” судалгааг удирдан хийлээ. Судалгааны хүрээнд улсын төсвийн ил тод байдал, төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоо, төрийн хяналтын байгууллагуудын зүгээс төсөвт тавих хяналтын өнөөгийн түвшнийг үнэлсэн бөгөөд үр дүнг 2024 онд дэлхий даяар танилцуулах юм. Түүнчлэн ОУТТ байгууллагын захиалгаар дараах судалгаануудыг амжилттай хийж, нийтийн хүртээл болгоод байна.

Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2024-2027 оны Үндэсний үйл ажиллагааны 5 дугаар төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэгт мөн Д.Оюунбадам менежер багтаж, төсвийн ил тод байдал, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр санал дэвшүүлэн ажиллалаа.

Уг төлөвлөгөө 2023 оны 12 дугаар сард батлагдсан юм. Төлөвлөгөөнд туссан үүрэг, амлалтыг хэрэгжүүлэх чиглэлээр ирэх онд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахаар төлөвлөж байна.



Нээлттэй засгийн түншлэлийн 2024-2027 оны Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний Зорилт 5 (Улсын төсөв, төсвийн хөрөнгө оруулалтад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх)-ын хүрээнд туссан үүрэг, амлалтууд

1. Төсвийн ил тод байдлыг дээшлүүлэх хүрээнд:

- Орон нутгийн төсвийн төлөвлөлтийн ил тод байдлыг хангахтай холбогдсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
- Улсын болон орон нутгийн тухайн оны төсвийн төслийн танилцуулга болон түүнтэй холбоотой хавсралтуудыг нээлттэй өгөгдлийн стандартад

нийцүүлэн ил тод, нээлтэй болгох зохицуулалтыг Шилэн дансны журамд тусгах.

- Тусгай сангийн төсвийг зарцуулах сонгон шалгаруулалт, санхүүжилт, төрийн өмчит компанийн 5 сая төгрөгөөс дээш худалдан авалттай холбогдох шийдвэр болон төрийн өмчийг актлах, устгах шийдвэрийг ил тод болгох зохицуулалтыг Шилэн дансны журамд тусгах.
- Тухайн жилийн төсвийн төсөлд тусгасан шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлсэнтэй холбоотой мэдээллийг ил болгох.
- Төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын хасагдсан, нэмэгдсэн болон төсвийн дүнд оруулсан өөрчлөлттэй холбоотой мэдээллийг хавсралтаар гаргадаг болох.

- Төсвийн хэрэгжилт, ил тод байдлын систем хоорондын уялдаа, талуудын оролцоог тэгш хангаж санал солилцох, судалгаан дээр тулгуурлан хөгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn сайтыг шинэчлэх.
- Гадаадын зээл тусламжтай холбоотой мэдээллийг www.odamis.mof.gov.mn системд бүртгэх, дэлгэрэнгүйгээр байршуулах, чиглэлийн уялдаа холбоог хангах, санхүүжилт болон үйл ажиллагааны үр дүнгийн уялдааг хангах, төслүүдийн худалдан авах үйл ажиллагааны журмыг олон нийтэд ил тод болгож сайжруулах.
- 2. Орон нутгийн төсвийн төслийг боловсруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.**

Цаашилбал, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн төсөлд улсын төсвийн чиглэлээр тусгуулах саналаа хүргүүлсэн юм. Уг хөтөлбөрийн Зорилго 7-д төсөв, санхүү, аудитын хяналтыг сайжруулан, худалдан авах ажиллагааны авлигын эрсдэлийг бууруулахаар тусгасан ба энэ хүрээнд тавигдсан зорилтуудаас дурдвал:

- Төсвийн төлөвлөлтийн тогтолцоог урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй үялдуулж, тэгш хүртээмжтэй, нээлттэй, олон нийтийн оролцоог хангах замаар бэхжүүлнэ.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн

бүртгэл, төлөвлөлт, ашиглалт, зарцуулалт, дуудлага худалдааг нээлттэй, боловсронгуй болгож, хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.

- Засгийн газрын өр, тусгай сан, гадаадын зээл, тусламжийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, менежментийг сайжруулах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.
- Худалдан авах ажиллагааг хэрэгцээ, шаардлагад үндэслэн төлөвлөх, хяналт тавих, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоно зэрэг болно.

ТӨСВИЙН ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭРХ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улс, орон нутгийн төсвийн зарцуулалтыг үр ашигтай болгох, төсөвт иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах үүднээс иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж ирлээ. Тухайлбал, “Монголын залуучуудын эвсэл” ТББ-аас хэрэгжүүлж буй “Нийслэл, 9 дүүргийн 2023 оны төсвийн зарлагыг ажиглах нь” төслийг санхүүжүүлэв. Уг ТББ төслийнхөө хүрээнд олон нийтийн сүлжээнд нөлөөллийн ажил хийж, нийслэлийн төсвийг олон нийтийн анхааралд оруулахаар зорьж байна. Төслийн

хүрээнд тус эвсэл фэйсбүүк дэх ([Mongolian Youth Council / Монголын Залуучуудын Эвсэл | Facebook](#)) хуудас болон твиттерийн ([twitter.com/MongolianYC](#)) хаягуудаараа төсвийн мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэсээр байна. Энэхүү төслийн хүрээнд төсвийн талаар тодорхой ойлголт, мэдээлэлтэй залуусын нэгдэл бий болгох зорилгоор “Төсвөө мэдье-Төсвөө мөшгөө” сэдэвт цуврал сургалт, арга хэмжээ зохион байгуулсан нь үр дүнгээ өгчээ.



“Төсвөө мэдье-төсвөө мөшгөө” сургалт, арга хэмжээнд оролцогсад, 2023 оны 3 дугаар сар

Онцолбол хотын ногоон байгууламж, амьдрах орчинд санаа тавин ажилладаг “Creative 100” гэх 100 залуусын нэгдэл тус байгууллагын төсвийн асуудлаарх компани

ажлыг сонирхож, залуучуудад мэдээлэл өгөх уулзалт хамтран зохион байгуулсан юм.



“Creative 100” залуучуудын нэгдэлд төсвийн мэдээлэл өгөх уулзалтын явцаас, 2023 оны 3 дугаар сар

Мөн “Монголын залуучуудын эвсэл” ТББ “Яасан бэ?” төслийн залуучуудтай хамтран “Төсвөө мэдье - Төсвөө мөшгөө урлаглаг графити” нэртэй арга хэмжээг зохион байгууллаа.

Төсөвт оролцох олон нийтийн сонирхлыг нэмэгдүүлэх үүднээс тус ТББ цахим орчинд “Хэн хамгийн сонирхолтой, хачирхалтай төсвийг олох вэ?” сэдэвт цуврал уралдаан зохион байгуулав. Түүнчлэн “Монголын дата клуб” ТББ-тай хамтран “Нийслэлийн төсвийн өгөгдлийг шинжлэх туршлагаа хуваалцах нь” сэдэвт уулзалт хийж, мэргэжлийн түвшний өгөгдлийн шинжээчидтэй хамтран нийслэлийн төсвийг үр дүнтэй шинжлэх арга туршлагаас суралцан, хамтран ажиллах эхлэл тавигдсан юм.



“Төсвөө мэдье-Төсвөө мөшгөө урлаглаг Графити” эвентийн явцаас. 2023 оны 5 дугаар сар

Түүнчлэн “Үнэн хатамж” ТББ “Төсвийн хяналт-Иргэний оролцоо” төслийнхөө хүрээнд улсын төсвийн асуудлаарх олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх онцгой анхаарч, төсвийн төлөвлөлт, хэрэгжилттэй холбогдолтой мэдээллийг цаг алдалгүй хүргэх ажлыг зохион байгуулж байна. Тус ТББ нь фэйсбүүк дэх “Сайн аудит” болон твиттерийн “Аудитын тухай ярилцъя” хуудсаараа дамжуулан улсын төсвийн холбогдолтой мэдээ, мэдээлэл, төрийн аудитын шинэ мэдээ, аудитын тайлан, УИХ-аар баталж буй улсын төсвийн холбогдолтой хуулиуд, хуулийн хэлэлцүүлгийн талаар мэдээ, мэдээлэл тогтмол бэлтгэн хүргэж байна.

ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР



ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ

Эрдэс баялгийн салбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд газрын болон ашигт малтмалын тухай хууль тогтоомжийг өөрчлөх үйл явц үргэлжилж, Барилга, хот байгуулалтын яам, Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны зүгээс хуулийн төслүүдийн шинэчилсэн хувилбарыг олон нийтэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан бодлогын тулгамдсан асуудлуудын шийдлийг тодорхойлох судалгаа шинжилгээ хийж, иргэний нийгэм, нутгийн иргэдийн дүү хоолойг бодлого боловсруулагчдад хүргэхэд анхаарч ажиллалаа.

Тухайлбал, хот суурины дахин төлөвлөлт, хөгжлийн бүтээн байгуулалтын зорилгоор газар чөлөөлөх шийдвэр гаргах ажиллагааг Захиргааны ерөнхий хуулиар тодорхойлсон төлөвлөлтийн эрх зүйн зохицуулалтад нийцүүлэх, газар чөлөөлөхөд нийгмийн "зайлшгүй хэрэгцээ"-г оновчтой тодорхойлох, нөхөн төлбөр тооцох журам, аргачлалыг хот суурин болон хөдөөгийн онцлогт тохируулан ялгамжтай тогтоох зэрэг асуудлаар бодлогын шинжилгээ хийж, холбогдох талуудад танилцууллаа.

Эрдэс баялгийн салбарт өрнөж буй энэ удаагийн эрх зүйн шинэчлэл нь Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд тусгалаа олсон тогтвортой хөгжлийн зарчим, үзэл санааг хэрэгжүүлэхэд чиглэх учиртай. Иймд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Үндсэн хуулийн үзэл санаанд нийцэж байгаа эсэхийг үнэлэх бодлогын шинжилгээ хийж, хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээтэй үялдуулах, ил тод байдал, орон нутгийн иргэдийн оролцоог хангах зэрэг нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэхэд чиглэсэн зөвлөмж хүргүүлэв.

<https://forum.mn/product/389321>


Уул уурхайн үйл ажиллагаа: Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ ба олон нийтийн оролцоо сэдэвт бодлогын шинжилгээгээр Үндсэн хуулийн 6.2-т заасан газрын хэвлийн баялаг ашиглах явцад иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, түүнтэй холбоотой мэдэх бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн тулд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан байгаль орчны хууль тогтоомжтой зөрчилдсөн буюу

дордуулсан заалтуудыг зайлшгүй өөрчлөх шаардлагатайг онцолсон юм.

Түүнчлэн ашигт малтмал өмчлөх эрх, түүний зохицуулалт сэдэвт бодлогын шинжилгээ хийж, төрийн нийтийн өмчийн газрын хэвлийн баялгийн өмчлөл, өмчлөх эрх шилжих нөхцөл, түүний зохицуулалтын хувилбарт санал дэвшүүлсэн болно.

Ашигт малтмалын тухай болон газрын багц хуулийн төслүүдийг орон нутагт танилцуулах цахим хэлэлцүүлгийг “Хүний эрх хөгжил төв”, “Хил хязгааргүй алхам” ТББ-үүдтай хамтран зохион байгуулав. Хэлэлцүүлэгт 21 аймгийн 143 сумын төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл нийт 1031 хүн оролцлоо. Оролцогчид шийдвэр гаргах түвшин дэх орон нутгийн оролцоог хумьсан, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны хариуцлагыг дордуулсан, орон нутгийн хөгжлийг дэмжих тал дээр ахиц дэвшил гаргаагүй зэрэг шүүмжлэлтэй байр суурь илэрхийлсэн юм. Түүнчлэн хуулийн төслийг бүхэлд нь байгаль орчны хууль тогтоомжид нийцүүлэх, ингэхдээ уул уурхайн тээвэр, дэд бүтцийн асуудлыг хамруулан цогцоор зохицуулах, тусгай зөвшөөрөл олгох шийдвэрийг нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд суурилсан хэлэлцүүлэгт тулгуурлан гаргах замаар хожим

хөрөнгө оруулагчдыг хохироох зөрчил маргаан гарахаас сэргийлэхийн чухлыг онцоллоо. Тэрчлэн чухал ашигт малтмал, түүний хайгуул олборлолтод тавих нөхцөл, шаардлагыг тодорхой болгох, бичил уурхайн болон түгээмэл тархацтай ашигт малтмалын үйл ажиллагааг нарийвчлан зохицуулах, тусгай хамгаалалттай нутагт оршин суугчдын газрын эрхийг баталгаажуулах, бэлчээр ашиглалт, хамгаалалтын асуудлыг уламжлалт мал аж ахуйн онцлогт нийцүүлэн оновчтой зохицуулах шаардлагатай талаар санал шүүмж гаргав. Хамгийн гол нь улс орны эдийн засаг, хүрээлэн буй орчны тогтвортой байдал, орон нутгийн иргэдийн амьдралын чанарт шүүд хамааралтай дээрх хуулийн төслүүдийг олон нийтээр, ялангуяа сумын түвшинд сайтар хэлэлцүүлэх шаардлагатайг тухайлан сануулж байв.



Дээрх бодлогын шинжилгээ болон олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнд тулгуурлан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг сайжруулахтай холбоотой хуулийн шүүмж боловсруулав. Түүнчлэн 2023 оны 10 дугаар сард Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас хуулийн төслийг шинэчлэн

танилцуулсантай холбоотойгоор Монголын хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хороотой хамтран хэлэлцүүлэг зохион байгуулж, хуулийн шүүмжийг шинэчлэн, холбогдох талуудад дахин хүргүүлээд байна.



Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэг. Зүүн гар талаас ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Эрдэнэчимэг. 2023 оны 10-р сарын 19. Хууль зүйн үндэсний хүрээлэн

Эрдэс баялгийн салбарт орон нутгийн харилцааны оновчтой зохицуулалт, шийдвэр гаргах түвшин дэх зохистой оролцооны асуудал олон жилийн турш шийдэл хүлээсээр буй. Байгалийн баялаг ашиглахтай холбоотой Засгийн газар, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын чиг үүргийн давхардал, тодорхойгүй байдлаас үүдэн орон нутагт тусгай зөвшөөрөл эзэмшигч, нутгийн захиргаа, иргэдийн дунд үл ойлголцол үүсэж, төслийн үйл ажиллагаанд саад учирдаг. Иймд газрын

хэвлийн баялаг ашиглах тухай шийдвэр гаргах тогтолцоо, түүнд оролцогч талуудын чиг үүргийн хуваарилалт, төслийн нөлөөлөлд өртөх иргэдийн зохистой оролцооны түвшнийг Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн үзэл санаанд тулгуурлан тодорхойлох зорилготой бодлогын судалгаа хийж, ашигт малтмал, байгаль орчны хууль тогтоомжид тусгах шийдлүүдийг боловсруулав.



Сүүлийн жилүүдэд хууль тогтоох үйл ажиллагааны чанар доройтож, үзэл баримтлалдаа нийцээгүй төсөл боловсруулах, хуулийн хэрэгжилт, үр нөлөөний үнэлгээ, хэрэгцээ шаардлагын тандан судалгаа, зардлын тооцоо зэргийг зохих ёсоор хийхгүй, олон нийт, эрх ашиг сонирхол нь хөндөгдөх талуудаар хэлэлцүүлэхгүй байх үзэгдэл ажиглагдах болсон билээ. Энэ байдал төсвийн тухай хууль, түүний дагалдах хуульд илүү тод ажиглагдах болсонтой холбоотойгоор төсвийн тухай хуулийн дагалдах хуулиудад дүн шинжилгээ хийлээ. Шинжилгээгээр дагалдах хуульд тавигдах шаардлагыг тодорхой болгох, түүний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах замаар тухайн батлагдаж буй хуулийн хэрэгжилтэд шууд хамааралгүй хууль тогтоомжийг дагалдуулан өөрчлөх, нэмэлт өөрчлөлт нэрээр хуулийн үзэл баримтлалыг өөрчлөхүйд зарчмын шинжтэй томоохон өөрчлөлт оруулах, анхдагч хуулийг дагалдах хууль нэрээр тооцоо судалгаа, олон нийтийн хэлэлцүүлэггүйгээр баталж буй явдлыг залруулахад чиглэсэн санал зөвлөмж гарган танилцуулав.


ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ

ННФ-ын стратегид шинээр туссан зорилтын нэг нь төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах асуудал юм. Энэхүү зорилтын хүрээнд судалгаа, дүн шинжилгээ, олон талт хэлэлцүүлгээр дамжуулан бодлого боловсруулах үйл ажиллагаанд хувь нэмэр оруулахын хамт иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн чадавхыг нэмэгдүүлж, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд анхаарч ажиллав.

Онцолбол, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийн шинэчилсэн хувилбарт дүн шинжилгээ хийж, санал шүүмжээ шинэчлэн хүргүүлэхийн зэрэгцээ төрийн өмчит компанийн засаглалын чухал асуудлуудаар бодлогын шинжилгээ хийж, олон нийтэд танилцууллаа.

Манай улсын хувьд ТӨК-тай холбоотой төрийн өмчлөлийн бодлого тодорхой болоогүй байна. Тодруулбал, Засгийн газар, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч

бусад байгууллагууд болон ТУЗ-ийн эрх хэмжээ бүрэн тусгаарлагдаагүй, томилгооноос үүдэлтэй ТУЗ-ийн хараат бус байдал бэхжиж чадаагүй, нэгэнт бие даан ажиллах чадамжгүй тул эргээд хариуцлага тооцож боломжгүй зэрэг нь ТӨК-ийн засаглал сул байгаагийн үндсэн шалтгаан болсоор ирсэн юм. Иймд “Төрийн өмчит компанийн ТУЗ-ийн бүрэн эрх ба хариуцлага” сэдэвт бодлогын шинжилгээ хийж, төрийн өмчийн эрх болон ТӨК дахь хувьцаа эзэмшигчийн эрхийг хуулиар ялган зааглаж, төр хувьцаа эзэмшигчийн хувьд компанийн үйл ажиллагаанд зөвхөн ТУЗ болон хувьцаа эзэмшигчдийн хурлаар дамжуулан оролцох, ТУЗ-ын мэргэшсэн, хараат бус байдлыг хангах, харин ТУЗ нь бие даан гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээх, ТУЗ-ийн шийдвэрт нөлөөлсөн этгээдийг тогтоон хариуцлага тооцох эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг санал шийдлийг дэвшүүлээ.



<https://forum.mn/product/306604>

“Төрийн өмчит компанийн нэгдлийн удирдлага, зохион байгуулалт” сэдэвт бодлогын шинжилгээгээр уул уурхайн компаниудын нэгдэл болох “Эрдэнэс Монгол” ХХК-ийн удирдлагын бүтэц, ялангуяа Засгийн газрын тогтоолд дурдсан группийн зарчмыг хэрэгжүүлж, үр ашигтай ажиллахад зайлшгүй анхаарах асуудлуудыг тодорхойлохыг зорив. Тухайлбал, төрийн өмчит холдинг компанийн хувьд Эрдэнэс Монгол нэгдлийн чиг үүргийг оновчтой тодорхойлж, стратеги болон бизнесийг салгах, группийн зарчмыг хэрэгжүүлэхэд хамаарал бүхий компаниудаа нүүрс, эрчим хүчний болон зэс, металл, дэд бүтцийн чиглэлээр бүлэглэн тэдгээрийн хувьцааг шинээр байгуулсан холдинг компанид шилжүүлэх, нэгдлийн хэмжээнд ТУЗ-ийн гишүүдийн тоог хатуу хязгаарлахгүй байх, дотоод хяналтын нэгдсэн тогтолцоог сайжруулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх зэрэг зөвлөмжийг санал болгов.


Засгийн газрын 2022 оны 225 дугаар тогтоолд “Үндэсний баялгийн сан бий болгох бэлтгэл хангах зорилгоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин, хараат компани болон бусад харьяа хуулийн этгээдийг нэгдлийн хэмжээнд нүүрс, эрчим хүчний болон зэс, металлын гэсэн үйл ажиллагааны чиглэлээр бүлэглэж, группийн зарчмаар

ажиллуулахаар” заажээ. Гэсэн хэдий ч “Эрдэнэс Монгол” нэгдэлд удирдлагын оновчтой тогтолцоог бүрдүүлэхэд нэр томьёоны зөрүүтэй байдлаас эхлээд анхаарах асуудлууд олон байгааг энэхүү шинжилгээний дүн харуулсан юм.

Харин “Төрийн өмчит компанийн онцгой дэглэм батерийн өмчлөгчийн хяналт” сэдэвт бодлогын шинжилгээ нь Засгийн газраас төрийн өмчит компанид онцгой дэглэм тогтоон бүрэн хяналтдаа авч байгаа асуудлыг хөндөн компанид удирдлагын хямрал үүсэж, үйл ажиллагаа доголдсон нөхцөлд төр өмчлөгчийн хувьд хяналтын эрхээ хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжийн хүрээнд ажиллан компанийн засаглалын зарчмыг зөрчихгүй байхыг чухалчлан сануулав. Өөрөөр хэлбэл, өнөөгийн эрх зүйн орчны хүрээнд компанийн дотоод болон хөндлөнгийн аудитын тогтолцоог бэхжүүлэх, гарсан зөрчлийг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлж, ТУЗ болон гүйцэтгэх захиралд хариуцлага тооцох боломж бүрэн байгааг онцолсон юм. Засгийн газраас 2019 онд “Монголросцветмет” ХХК, “Эрдэнэт Үйлдвэр” ХХК, 2022 онд “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой Төмөр зам” ХХК, “Тавантолгой” ХК-д онцгой дэглэм тогтоохдоо 1991 онд батлагдсан шилжилтийн үед

эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий хууль буюу БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг үндэслэл болгосон нь Монгол Улсын Үндсэн хууль болон Иргэний хууль, Компанийн тухай хуулийн үзэл санаа, зохицуулалтад нийцэхгүй хэмээн судлаачид дүгнэсэн юм.

“Хөгжлийн төлөө өгөгдөл” ТББ-аас ННФ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн төрийн нээлттэй мэдээллийг ашиглан уул уурхайн салбар дахь төрийн өмчит компанийн худалдан авалтад хяналт тавих төслийн хүрээнд бэлтгэгдсэн дата сэтгүүл зүйн зарим бүтээлүүд энэ онд сэтгүүл зүйн нэр хүндтэй уралдаанд шалгарчээ.



<https://forum.mn/product/340310>

Сэтгүүлч Ц.Мягмарбаяр, Б.Энхзаяа, Д.Энхдулам, А.Маралмаа нарын хамтран бичсэн “Нүүрс тээврийн С зөвшөөрлийг сингапур, хятад компаниуд түүж, монгол жолооч нарыг шахаж байна” нийтлэл эрэн сурвалжлах сэтгүүл зүйн шилдэг бүтээл шалгаруулах “Цахиур” уралдааны дэд байрын шагнал хүртсэн бол сэтгүүлч З.Цэлмэг, С.Уянга, Б.Эрдэнэчимэг нарын “Дөрвөн толгой залгисан Тавантолгой ба дүр эсгэсэн ТУЗ-ийн засаглал” нийтлэл “Анрийд медиа”-аас жил бүр гаргадаг “Атаархлын жагсаалт” буюу онцлох нийтлэлийн жагсаалтад оржээ.

Төслийн хүрээнд байгуулагдсан “Монголын дата клуб” ТББ үйл ажиллагаагаа тогтвортой үргэлжлүүлэн 200 гаруй гишүүнтэй болж, засаглал, нээлттэй өгөгдөл, дата анализын хөгжил, нийгмийн асуудлын шийдлийг ярилцах

“DataMeetUP” уулзалтыг сар бүр зохион байгуулж хэвшив.

Тэрчлэн Төрийн бүтээмжийн хорооны дэргэдэх Төрийн өмчит компанийн сэргэлтийн дэд хороонд “Хөгжлийн төлөө өгөгдөл” ТББ-ын төлөөлөл багтан ажиллах болсноор өгөгдлийн шинжилгээний дүнд үндэслэн гаргасан төрийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулах санал зөвлөмжийг ажил хэрэг болгох боломж нэмэгдлээ.

“Хөгжлийн төлөө өгөгдөл” ТББ, үүсгэн байгуулагч “Монголын дата клуб” ТББ-ын үйл ажиллагаа, дата сэтгүүл зүйн бүтээлүүдтэй танилцахыг хүсвэл www.datastory.mn болон <https://www.facebook.com/MongolianDataClub/> хуудсаар зочлоорой.



НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ НЭХЭМЖЛЭН ХАМГААЛАХ

ННФ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах төслүүдийн хүрээнд дараах үр дүн энэ онд гарчээ.

- “Их бага Баяншарга” ТББ-ын нэхэмжлэлтэй Дундговь аймагт олгогдсон цацраг идэвхт ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлүүдийг цуцлуулах хэрэг захиргааны шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэв. Анх 2021 оны 1 сард гаргасан нэхэмжлэлийг шүүхээс 2 удаа буцаасны эцэст 2021 оны 8 сард захиргааны хэрэг үүсгэн ийнхүү 2 жилийн дараа эцэслэн шийдвэрлэжээ. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхээс 2023 оны 3 сард гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, Дундговь аймгийн нэр бүхий сумдад олгогдсон цацраг идэвхт ашигт малтмал ашиглах 3 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай шийдвэрийг захиргааны хэргийн давж заалдах болон хяналтын шатны шүүх хариуцагч, гуравдагч этгээдийн гомдлоор хянан хэлэлцээд хэвээр үлдээсэн нь 2023 оны 9 сард хүчин төгөлдөр болжээ. Цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл явцад гарч буй хууль тогтоомжийн зөрчлийг ийнхүү шүүхээр тогтоолгосон нь цаашид энэ чиглэлийн үйл ажиллагаанд оролцогчдын хариуцлагыг нэмэгдүүлж, хуулийн хэрэгжилтийг сайжруулахад хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.
- Г.Мандахсайхан ахлагчтай хуульчдын багийн хэрэгжүүлсэн тусгай хамгаалалттай газар нутагт гарч буй хуулийн зөрчлийг арилгаж, орон нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах төслийн үр дүнд БОАЖЯ-аас Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт үе дамжин амьдарчирсэн мал бүхий иргэдийн эрхийг баталгаажуулж, газар ашиглах гэрчилгээ олгожээ. Тэрчлэн шинэчлэн боловсруулагдаж байгаа Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай

хуулийн төсөлд орон нутгийн иргэдийн газрын эрхийг баталгаажуулахтай холбоотой заалтууд тусгаад байна. 2019 онд шинэчлэн батлагдсан Өмгөөллийн тухай хуулиар бий болсон өмгөөлөгч нийтийн эрх, ашгийг хамгаалах зорилгоор өөрийн нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах боломжийг хэрэгжүүлэх хүрээнд энэ чиглэлээр хуульчдын санаачилгыг дэмжин тэтгэлэг олгосны нэг нь энэхүү төсөл юм. Харин өмгөөллийн "Фиделитас Партнерс" ХХН-д олгосон тэтгэлгийн хүрээнд төрийн холбогдох байгууллагуудын цар тахлын үеийн хандив тусламжийн зарцуулалтын мэдээллийг ил тод болгосон талаар өмнөх жилийн тайланд дурдсан билээ. Эдгээр үр дүн нь стратегийн өмгөөллийн нөлөөллийн ажлын үр дүн байсан бөгөөд Өмгөөллийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийг нэг мөр хэрэглэх практик тогтоогүйгээс дээрх 2 тэтгэлгийн хүрээнд өмгөөлөгчдийн гаргасан нэхэмжлэлийг захиргааны шүүх хүлээн авахаас татгалзсан билээ.

- “Буйр нуур, Халхгол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн” ТББ-ын гаргасан газрын тосны нөөц ашигласны төлбөрийн тодорхой хувийг орон нутагт хуваарилах асуудлаарх мэдээллийг Үндсэн хуулийн цэц хүлээн авч, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгээд байна.

Харин 2023 оны 7 дугаар сард Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай Улсын дээд шүүхийн тогтоол гарснаар өмгөөлөгч нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор өөрийн нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргахад Өмгөөлөгчдийн холбооноос томилот авах шаардлагагүй болж, энэ төрлийн нэхэмжлэлд тулгарч байсан нэг саад арилсан юм. Гэсэн хэдий ч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасны дагуу нийтийн ашиг сонирхлыг



төлөөлөн нэхэмжлэл гаргах төрийн бус байгууллагын эрхийг тодорхойлоход тулгардаг бэрхшээл бүрэн арилагүй байна. Тухайлбал, шүүхээс төрийн бус байгууллагын дүрмийн зорилгод субъектив дүгнэлт хийх, сүүлийн 3 жилийн тогтвортой үйл ажиллагааг тогтооход татварын хууль тогтоомжийг харилцан адилгүй байдлаар хэрэглэж, үйл ажиллагаатай холбоотой нийтэд илэрхий үйл баримтыг үл харгалзан зөвхөн төрийн байгууллагаас ирүүлсэн лавлагааг үндэслэх зэрэг асуудал гарсан хэвээр байна. Иймд

ННФ-ын зүгээс энэ асуудалд дүн шинжилгээ хийж, холбогдох талуудын дунд хэлэлцүүлэг өрнүүлэхээр төлөвлөж байна. Тэрчлэн нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах чиглэлээр өмгөөлөгчдийн чадавхыг бэхжүүлэх, идэвх оролцоог нэмэгдүүлэх хүрээнд хуульчдын үргэлжилсэн сургалтын хөтөлбөр боловсруулж, ХЭҮК-оос дамжуулан Монголын хуульчдын холбоонд магадлан итгэмжлүүлэхээр хүргүүлээд байна.



САНХҮҮГИЙН ТАЙЛАН



НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

мянган төгрөг

Хөтөлбөр	Тэтгэлгийн зардал	Үйл ажиллагааны зардал	Нийт зардал
АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛ			
Ардчиллын институцийг бэхжүүлэх нь	42,492	399,208	441,700
Иргэний оролцоог дэмжих нь	30,691	329,090	359,781
ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГО			
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь	109,248	451,174	560,421
НИЙТИЙН БАЯЛГИЙН УДИРДЛАГА, ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ			
Төсвийн хариуцлагыг сайжруулах нь	-	489,860	489,860
Эрдэс баялгийн салбарт сайн засаглалыг дэмжих нь	22,929	385,201	408,130
БУСАД			
Хаагдсан тэтгэлгүүд	(36,160)	-	(36,160)
ЗАХИРГАА		878,734	878,734
ТАТВАРЫН ЗАРДАЛ		82,263	82,263
НИЙТ ДҮН		169,199	3,015,531
			3,184,730



2023 ОНД ОЛГОСОН ТЭТГЭЛГИЙН ЖАГСААЛТ (ХӨТӨЛБӨРӨӨР)

мянган төгрөг

Хөтөлбөр	Байгууллагад олгосон тэтгэлэг	Хувь хүнд олгосон тэтгэлэг	Нийт тэтгэлгийн дүн
АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛ			
Ардчиллын институцийг бэхжүүлэх нь	-	42,492	42,492
Иргэний оролцоог дэмжих нь	30,691	-	30,691
ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ БОДЛОГО			
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь	69,375	39,873	109,248
НИЙТИЙН БАЯЛГИЙН УДИРДЛАГА, ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ			
Эрдэс баялгийн салбарт сайн засаглалыг дэмжих нь	-	22,929	22,929
НИЙТ ОЛГОСОН ТЭТГЭЛЭГ	100,065	105,294	205,359
ХААГДСАН ТЭТГЭЛГҮҮД	(30,604)	(5,556)	(36,160)
НИЙТ ДҮН	69,461	99,738	169,199

2023 ОНД ОЛГОСОН ТЭТГЭЛГИЙН ЖАГСААЛТ (ТӨРЛӨӨР)

мянган төгрөг

№	Байршил	Тэтгэлэг авагч байгууллага, иргэн	Төслийн нэр	Төрөл	Тэтгэлгийн дүн
1	Улаанбаатар	ГАНЗОРИГ Зоригтбаатар	Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимаас хэрэг маргааныг хяналтын хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэж буй байдалд хийсэн дүн шинжилгээ	Иргэн	9,620
2	Улаанбаатар	ЦЭРЭНБАТ Минжүүр	Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ	Иргэн	3,250
3	Улаанбаатар	БАЯСГАЛАН Гунгаа	Үндсэн хуулийн хяналт болон сонгуулийн удирдлагын хүрээнд суралцах аялал	Иргэн	5,886
4	Улаанбаатар	ҮНЭНБАТ Маамба	Үндсэн хуулийн хяналт болон сонгуулийн удирдлагын хүрээнд суралцах аялал	Иргэн	5,886
5	Улаанбаатар	МӨНХБОЛОР Лхагва	Үндсэн хуулийн хяналт болон сонгуулийн удирдлагын хүрээнд суралцах аялал	Иргэн	5,897
6	Улаанбаатар	МӨНХОРГИЛ Цэнд	Үндсэн хуулийн хяналт болон сонгуулийн удирдлагын хүрээнд суралцах аялал	Иргэн	5,886
7	Улаанбаатар	ГАНГАБААТАР Дашбалбар	Үндсэн хуулийн хяналт болон сонгуулийн удирдлагын хүрээнд суралцах аялал	Иргэн	5,886
8	Улаанбаатар	БОР Лосол	Open Government Partnership Global Summit хуралд оролцох	Иргэн	11,464
9	Улаанбаатар	НАРАНЦЭЦЭГ Нанзад	Open Government Partnership Global Summit хуралд оролцох	Иргэн	11,464
10	Улаанбаатар	Улс төрийн боловсролын академи	Монгол дахь ардчиллын хөгжлийг дэмжихүй - Эрдэм шинжилгээний хурал	Байгууллага	7,760
11	Улаанбаатар	Хөгжих Эрх Судлал Тулгуур ТББ	Хорих болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд хийсэн мониторинг	Байгууллага	12,750
12	Улаанбаатар	Хууль Эрх Зүйн Хөгжлийн Хүрээлэн	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн мониторинг	Байгууллага	14,999

№	Байршил	Тэтгэлэг авагч байгууллага, иргэн	Төслийн нэр	Төрөл	Тэтгэлгийн дүн
13	Дархан-Уул	Хүчирхийллийн Эсрэг Төв (Дархан-Уул)	Хүүхдийн тэтгэлгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн мониторинг	Байгууллага	15,300
14	Улаанбаатар	БОЛОРМАА Солоон	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн ил тод байдлын мониторинг	Иргэн	14,805
15	Улаанбаатар	АДИЛМАА Хүрэл-Очир	Хангайн бүсийн аймгуудын мониторинг	Иргэн	12,198
16	Улаанбаатар	Иргэний Нийгмийн Байгууллагуудын Хамтын Хүч Түншлэл	Орхон, Өвөрхангай, Дундговь, Хөвсгөл аймаг дахь сум дундын ЭХАШШ, ЭХДЗШШШ-ийн цахим сангийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдалд дүн шинжилгээ хийх	Байгууллага	11,826
17	Улаанбаатар	Бодлогод Залуусын Хяналт НҮТББ	Иргэний нийгмийн байгууллагуудын урт хугацааны тогтвортой үйл ажиллагаа, хөгжлийг дэмжихэд бодитой хувь нэмэр оруулах зорилын хүрээнд байнгын үйл ажиллагаа явуулах оффисын талбай эзэмшүүлэх	Байгууллага	3,822
18	Улаанбаатар	ЦОГЦ ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТББ	Иргэний нийгмийн байгууллагуудын урт хугацааны тогтвортой үйл ажиллагаа, хөгжлийг дэмжихэд бодитой хувь нэмэр оруулах зорилын хүрээнд байнгын үйл ажиллагаа явуулах оффисын талбай эзэмшүүлэх	Байгууллага	3,822
19	Улаанбаатар	ЭССТ НҮТББ (Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө)	Иргэний нийгмийн байгууллагуудын урт хугацааны тогтвортой үйл ажиллагаа, хөгжлийг дэмжихэд бодитой хувь нэмэр оруулах зорилын хүрээнд байнгын үйл ажиллагаа явуулах оффисын талбай эзэмшүүлэх	Байгууллага	3,822
20	Улаанбаатар	Хууль Эрх Зүйн Хөгжлийн Хүрээлэн	Иргэний нийгмийн байгууллагуудын урт хугацааны тогтвортой үйл ажиллагаа, хөгжлийг дэмжихэд бодитой хувь нэмэр оруулах зорилын хүрээнд байнгын үйл ажиллагаа явуулах оффисын талбай эзэмшүүлэх	Байгууллага	3,822

№	Байршил	Тэтгэлэг авагч байгууллага, иргэн	Төслийн нэр	Төрөл	Тэтгэлгийн дүн
21	Улаанбаатар	Хөгжлийн Төлөө Өгөгдөл ТББ	Иргэний нийгмийн байгууллагуудын урт хугацааны тогтвортой үйл ажиллагаа, хөгжлийг дэмжихэд бодитой хувь нэмэр оруулах зорилын хүрээнд байнгын үйл ажиллагаа явуулах оффисын талбай эзэмшүүлэх	Байгууллага	3,822
22	Улаанбаатар	Монголын Эмэгтэйчүүдийн Хөдөлмөрийг Дэмжих Холбоо	Иргэний нийгмийн байгууллагуудын урт хугацааны тогтвортой үйл ажиллагаа, хөгжлийг дэмжихэд бодитой хувь нэмэр оруулах зорилын хүрээнд байнгын үйл ажиллагаа явуулах оффисын талбай эзэмшүүлэх	Байгууллага	3,822
23	Улаанбаатар	МАНДХАЙХАТАН Цэвэгмид	OGP Global summit хуралд оролцох	Иргэн	6,525
24	Улаанбаатар	ЭНХБАДРАЛ Мягмар	OGP Global summit хуралд оролцох	Иргэн	6,525
25	Улаанбаатар	Монголын Хуульчдын Холбоо	Авлигын гэмт хэрэгт оногдуулсан ялын бодлогын үр нөлөө	Байгууллага	14,500
НИЙТ ОЛГОСОН ТЭТГЭЛЭГ					205,359
Хаагдсан тэтгэлгүүд					(36,160)
НИЙТ ДҮН					169,199



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД, АЖИЛТНУУД

Удирдах Зөвлөлийн гишүүд

О.Мөнхсайхан	Удирдах зөвлөлийн дарга, МУИС-ийн ХЗС-ийн профессор, Хууль зүйн доктор
Ж.Үнэнбат	Удирдах зөвлөлийн гишүүн, Компанийн засаглалын хөгжлийн төв ТББ-ын зөвлөх
П.Наранбаяр	Удирдах зөвлөлийн гишүүн, Сайн сургуулийг таны дэргэд ТББ-ын тэргүүн
Д.Энхжаргал	Удирдах зөвлөлийн гишүүн, МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээний Ерөнхий зохицуулагч
Ч.Болортуяа	Удирдах зөвлөлийн гишүүн, Ерөнхий сайдын зөвлөх

Гүйцэтгэх захирал

П.Эрдэнэжаргал

Ажилтнууд

Ж.Алтанчимэг	Нягтлан бодогч, тэтгэлгийн менежер
Б.Амгалан	Оффис менежер
П.Бадамрагчаа	Эрх зүйн хөтөлбөрийн менежер
Б.Бат-Эвлэл	Захиргааны туслах ажилтан
А.Гэрэлмаа	Иргэний нийгмийн орон зайн хөтөлбөрийн менежер
Б.Мөнхгэрэл	Мэдээллийн ажилтан
Д.Оюунбадам	Засаглалын хөтөлбөрийн менежер
Б.Ундармаа	Хөтөлбөрийн зохицуулагч
О.Сэлэнгэ	Хөтөлбөрийн зохицуулагч
Э.Сайнтүвшин	Мэдээлэл, технологийн менежер
В.Халиунцэцэг	Санхүүгийн менежер
Д.Эрдэнэчимэг	Засаглалын хөтөлбөрийн менежер
Д.Энхцэцэг	Засаглалын хөтөлбөрийн менежер

Нийтлэг И-мэйл: osf@forum.mn